



2020 оны 01 дүгээр сарын 22
№03 /1105/

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

**Монгол Улсын
хууль**

**Иргэний тэтгэвэр барьцаалсан
зээлийн төлбөрийг төрөөс нэг
удаа төлөх тухай**

**Монгол Улсын
Их Хурлын
тогтоол**

**Монгол Улсын Үндсэн хуульд
оруулсан нэмэлт, өөрчлөлтөд
хууль тогтоомжийг нийцүүлэх,
түүнтэй холбогдуулан авах арга
хэмжээний тухай**

**Монгол Улсын
олон улсын
гэрээ**

**Ялтан шилжүүлэх тухай
Монгол Улс болон Бүгд
Найрамдах Социалист Вьетнам
Улс хоорондын гэрээ**

ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

24.	Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр, зээлийн болон төслийн гэрээ соёрхон батлах тухай	94
25.	Гэрээ соёрхон батлах тухай	94
26.	Санхүүгийн хамтын ажиллагааны ерөнхий хөтөлбөрийн тухай хэлэлцээрийн нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай	95
27.	Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай	95
28.	Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуульд нэмэлт оруулах тухай	98
29.	Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай	99

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

30.	Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр томилох, гишүүнээс чөлөөлөх тухай	Дугаар 01	100
31.	Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай	Дугаар 02	100
32.	Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах арга хэмжээний тухай	Дугаар 04	115
33.	Хуулийн төсөл буцаах тухай	Дугаар 05	116

МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

34.	Санхүүгийн хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Засгийн газар хоорондын Хэлэлцээр	117
35.	Зээлийн болон төслийн гэрээ	120



36.	Ялтан шилжүүлэх тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс хоорондын гэрээ	131
37.	Санхүүгийн хамтын ажиллагааны ерөнхий хөтөлбөрийн тухай Монгол Улсын Засгийн газар, Унгар Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр Нэмэлт, өөрчлөлт	140

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр

Улаанбаатар хот

САНХҮҮГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХЭЛЭЛЦЭЭР, ЗЭЭЛИЙН БОЛОН ТӨСЛИЙН ГЭРЭЭ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газар, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Засгийн газар хооронд 2018 оны 06 дугаар сарын 22-ны өдөр байгуулсан “Төвийн бүсийн цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний үр ашгийг дээшлүүлэх төсөл”-ийн Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр, Зээлийн болон төслийн гэрээг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр

Улаанбаатар хот

ГЭРЭЭ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улс болон Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс хооронд 2018 оны 10 дугаар сарын 16-ны өдөр байгуулсан “Ялтан шилжүүлэх тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс хоорондын гэрээ”-г Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны 12 дугаар
сарын 20-ны өдөр

Улаанбаатар
хот

САНХҮҮГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ХӨТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХЭЛЭЛЦЭЭРИЙН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Санхүүгийн хамтын ажиллагааны ерөнхий хөтөлбөрийн тухай Монгол Улсын Засгийн газар, Унгар Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн нэмэлт, өөрчлөлтийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 01 дүгээр
сарын 10-ны өдөр

Улаанбаатар
хот

ИРГЭНИЙ ТЭТГЭВЭР БАРЬЦААЛСАН ЗЭЭЛИЙН ТӨЛБӨРИЙГ ТӨРӨӨС НЭГ УДАА ТӨЛӨХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авагч болон цэргийн алба хаасны тэтгэвэр авагч иргэний тэтгэвэр барьцаалан банкнаас авсан зээлийн үлдэгдэл төлбөрийн тодорхой хэсгийг төрөөс нэг удаа хариуцан төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Тэтгэврийн зээлийг төрөөс нэг удаа төлөхтэй холбоотой хууль тогтоомж

2.1. Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль², Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан

¹ Монгол Улсын Үндсэн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1992 оны 01 дугаарт нийтлэгдсэн.

² Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1994 оны 08 дугаарт нийтлэгдсэн.



өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль³, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль⁴, Төв банк /Монголбанк/-ны тухай хууль⁵, Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хууль⁶, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1.“тэтгэвэр барьцаалсан зээл” гэж энэ хуулийн 3.1.2-т заасан иргэний тэтгэврээ барьцаалан банкнаас гэрээний үндсэн дээр зээлсэн мөнгөн хөрөнгийг;

3.1.2.“тэтгэвэр авагч” гэж Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2, 3 дахь заалт, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2 дахь заалт, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2, 3 дахь заалтад хамаарах тэтгэвэр авагч иргэнийг.

4 дүгээр зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

4.1.Энэ хуулийн үйлчлэлд 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийн үлдэгдэлтэй энэ хуулийн 3.1.2-т заасан Монгол Улсын иргэн хамаарна.

4.2.Нас барсан иргэний тэтгэвэр барьцаалсан зээл 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд үлдэгдэлтэй бол энэ хуулийн үйлчлэлд хамрагдана.

4.3.Тэтгэвэр авагч 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс өмнө тэтгэвэр барьцаалсан зээл авч зээлийн төлбөрөө бүрэн барагдуулсан бол энэ хуулийн үйлчлэлд хамаарахгүй.

4.4.Энэ хуулийн 4.1, 4.2-т заасан зээлдэгчийн зургаан сая төгрөг, түүнээс доош дүнтэй зээлийн төлбөрийг төлөх бөгөөд үлдэгдэл зээлийн төлбөрийг зээлдэгч өөрөө хариуцна.

³ Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1994 оны 08 дугаарт нийтлэгдсэн.

⁴ Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1994 оны 08 дугаарт нийтлэгдсэн.

⁵ Төв банк /Монголбанк/-ны тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1996 оны 11 дугаарт нийтлэгдсэн.

⁶ Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хууль Хууль тогтоомжийн эмхэтгэлийн 2017 оны 09 дугаарт нийтлэгдсэн.

5 дугаар зүйл.Тэтгэвэр барьцаалсан зээлийг төлөх арга хэмжээ, түүний санхүүжилтийн эх үүсвэр

5.1.Төрийн өмчит “Эрдэнэс Монгол” ХХК өөрийн охин компанийн зээмшлийн Салхитын мөнгө, алтны ордыг эдийн засгийн эргэлтэд оруулсан орлогоос төрд ногдох өгөөжийг барьцаалан үнэт цаас гаргах замаар иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн тодорхой хэсгийг төлнө.

5.2.Төрийн өмчит “Эрдэнэс Монгол” ХХК иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн үүргийг үнэт цаас гаргаж төлөх гэрээг холбогдох банк тус бүртэй байгуулна.

5.3.Монгол Улсын Хөгжлийн банк энэ хуулийн 5.1-д заасан үнэт цаасанд хууль тогтоомжид нийцүүлэн бие даан баталгаа гаргах бөгөөд уг баталгаанд зориулж төрийн өмчийг барьцаалахад Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн⁷ 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт хамаарахгүй.

5.4.Монголбанк энэ хуулийн 5.1-д заасан үнэт цаасыг Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 2, 4 дэх заалтад заасан хэрэгслийг ашиглан худалдан авна.

5.5.Тэтгэврийн зээлийг төлөхтэй холбоотойгоор энэ хуулийн 5.1-д заасан төрийн өмчит компани зээл авах болон үнэт цаас гаргахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 16 дахь хэсэгт заасан зөвшөөрлийг авахгүй.

5.6.Энэ хуулийн 5.4-т заасны дагуу үнэт цаас эзэмшсэнээс Монголбанкны өөрийн хөрөнгө буурсан тохиолдолд Засгийн газар үнэт цаас гаргаж, Монголбанканд эзэмшүүлэх замаар нөхнө.

5.7.Энэ хуулийн 5.4-т заасны дагуу Монголбанк үнэт цаас худалдан авахад Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4, 7 дахь заалт хамаарахгүй.

6 дугаар зүйл.Тэтгэвэр барьцаалсан зээлийг төлөх журам

6.1.Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас тэтгэвэр авагчийн мэдээллийг харилцагч банканд хүргүүлнэ.

6.2.Банк тэтгэвэр авагчтай зээлийн үлдэгдэл төлбөрийн тооцоог баталгаажуулан нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

⁷ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1996 оны 11 дугаарт нийтлэгдсэн.



6.3.Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 6.2-т заасан мэдээллийг холбогдох банк тус бүрээр гаргаж, төрийн өмчит “Эрдэнэс Монгол” ХХК-д хүргүүлнэ.

6.4.Энэ хуулийн 5.2-т заасан гэрээ байгуулснаар зээлийн төлбөрийн үүрэг дуусгавар болсонд тооцно.

7 дугаар зүйл.Үйл ажиллагааны хяналт, тайлагналт

7.1.Энэ хуулийн хэрэгжилтийг Засгийн газар 2020 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд багтаан Монгол Улсын Их Хуралд танилцуулна.

8 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

8.1.Энэ хуулийг 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 01 дүгээр
сарын 10-ны өдөр

Улаанбаатар
хот

БАНК, ЭРХ БҮХИЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН МӨНГӨН ХАДГАЛАМЖ, ТӨЛБӨР ТООЦОО, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 29 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 9 дэх хэсэг нэмсүгэй:

“9.Зээлдүүлэгч зээлдэгчийн тэтгэврийг жилд нэг удаа зургаан сараас дээш хугацаагаар барьцаалахыг хориглоно.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 01 дүгээр
сарын 10-ны өдөр

Улаанбаатар
хот

ИРГЭНИЙ ТЭТГЭВЭР БАРЬЦААЛСАН ЗЭЭЛИЙН ТӨЛБӨРИЙГ ТӨРӨӨС НЭГ УДАА ТӨЛӨХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

1 дүгээр зүйл.Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хууль баталсантай холбогдуулан тэтгэвэр барьцаалсан зээл аваагүй тэтгэвэр авагчид Салхитын мөнгө, алтны ордыг эдийн засгийн эргэлтэд оруулсан орлогыг барьцаалан гаргах үнэт цааснаас 1.0 сая төгрөгтэй тэнцэх дүнтэй үнэт цаасыг эзэмшүүлнэ.

2 дугаар зүйл.Төрийн өмчит “Эрдэнэс Монгол” ХХК Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан үнэт цаасыг жилийн 6 хувийн хүүтэй, 5 жилийн хугацаатай нийт 900.0 тэрбум төгрөгийн хямдруулсан дүнтэй гаргаж, уг хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4-т заасан тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх, энэ хуулийн 1, 4 дүгээр зүйлд заасан үнэт цаасыг энэ хуулийн 3 дугаар зүйлд заасны дагуу мөнгөжүүлэх болон “Эрдэнэс силвер ресурс” ХХК-ийн үйл ажиллагаанд тус тус зарцуулна.

3 дугаар зүйл.Энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан иргэнд эзэмшүүлэх 1.0 сая төгрөгтэй тэнцэх дүнтэй үнэт цаас болон 4 дүгээр зүйлд заасан үнэт цаасыг 2021 оны 05 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэн мөнгөжүүлнэ.

4 дүгээр зүйл.Тэтгэвэр барьцаалсан зээлтэй иргэний зээлийн үлдэгдэл төлбөр нь энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан хэмжээнээс бага байвал зөрүү төлбөрийн дүнтэй тэнцүү хэмжээний үнэт цаасыг тухайн иргэнд эзэмшүүлнэ.

5 дугаар зүйл.Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төрийн өмчит “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гаргасан үнэт цаасны хүүгийн зардлыг бууруулах зорилгоор үнэт цаасыг банк эзэмших хугацаанд нийгмийн даатгалын сангийн чөлөөт мөнгөн хөрөнгөөс хөнгөлөлттэй хүүтэй хадгаламж байршуулж болно.

6 дугаар зүйл.Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хууль болон энэ хуулийг хэрэгжүүлэх үйл ажиллагаатай холбоотой журмыг Засгийн газар батална.



7 дугаар зүйл.Энэ хуулийг Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 01 дүгээр
сарын 08-ны өдөр

Дугаар 01

Улаанбаатар
хот

**Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр
томилгох, гишүүнээс чөлөөлөх тухай**

Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2, 4.5 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр Гочоосүрэнгийн Байгалмаа, Эрдэнэбилэгийн Батболд, Одонмажигийн Амгаланбаатар, Дугардоржийн Баяндүүрэн, Бямбажавын Ганбат нарыг томилсугай.

2.Бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болсон тул Баянмөнхийн Билэгт, Дашзэвэгийн Эрдэнэчулуун, Нацагийн Дагва нарыг Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээс чөлөөлсүгэй.

3.Энэ тогтоолыг 2020 оны 01 дүгээр сарын 17-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 01 дүгээр
сарын 09-ний өдөр

Дугаар 02

Улаанбаатар
хот

**Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт,
өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх,
түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай**

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн агуулга, үзэл санаанд холбогдох хууль тогтоомжийг нийцүүлж эрх зүйн шинэтгэлийг хэрэгжүүлэх, ач холбогдлыг нь ард түмэнд сурталчлан таниулах зорилтыг

эш үндэс болгож, Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн 1 дүгээр зүйл, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарийг хавсралтаар баталсугай.

2.Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулж доор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т даалгасугай:

1/Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх ажлыг төлөвлөгөөний дагуу зохион байгуулах;

2/Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг иргэдэд сурталчлах ажлыг улс орон даяар зохион байгуулах.

3.Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг иргэдэд сурталчлах ажилд шаардагдах зардлын төсвийг баталж, Засгийн газрын нөөц сангаас гаргахыг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т зөвшөөрсүгэй.

4.Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг иргэдэд сурталчлахыг Улсын Их Хурлын нийт гишүүнд даалгасугай.

5.Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг улс орон даяар сурталчлах ажлыг зохион байгуулахад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэхийг Монгол Улсын Их Хурлын Тамгын газар /Л.Өлзийсайхан/-т даалгасугай.

6.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо /С.Бямбацогт/-нд даалгасугай.

7.Энэ тогтоолыг 2020 оны 01 дүгээр сарын 17-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР



Монгол Улсын Их Хурлын 2020 оны
02 дугаар тогтоолын хавсралт

**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬД ОРУУЛСАН
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТӨД ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ
НИЙЦҮҮЛЭХ ХУВААРЬ**

**НЭГ.ПАРЛАМЕНТЫН АРДЧИЛЛЫГ ТӨЛӨВШҮҮЛЖ,
АРД ТҮМНИЙ ЗАСАГЛАХ ЭРХИЙГ ХАНГАХ**

**1.1.Байгалийн баялгийн зохицуулалтын талаарх нэмэлт,
өөрчлөлттэй холбогдуулан боловсруулах хуулийн төсөлд дараах
чиглэл баримтална:**

1.1.1.байгалийн баялаг ард түмний мэдэлд, төрийн нийтийн өмч байх эрх зүйн орчныг бүрдүүлэхдээ энэхүү баялгийг төр өмчлөх, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд ашигласны үр өгөөж /татвар, ашиг гэх мэт/-ийн дийлэнх нь буюу тавиас дээш хувь нь монголын ард түмэнд ногдох, шаардлагатай бол иргэдийн саналыг харгалзан Улсын Их Хурал хэлэлцэн шийдвэрлэх зарчмыг хуульчлах;

1.1.2.Үндэсний баялгийн сан нь хөгжлийн болон хуримтлалын сан байх бөгөөд стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын нөөц ашигласны төлбөр, төрийн өмчийн хувьцаа борлуулсны орлого, газрын тос, байгалийн хийн бүтээгдэхүүн хуваах гэрээний орлого, төрийн өмчийн хувьцааны ногдол ашиг, сангийн хөрөнгө оруулалтын цэвэр ашгийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлэх;

1.1.3.сангийн хөрөнгийн удирдлагын компани уг сангийн хөрөнгийн удирдлагыг хараат бусаар бие даан хэрэгжүүлэх, компанийн болон сангийн удирдлагын сайн засаглалыг хэвшүүлэх, сангийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг зохистой хэлбэрээр хэрэгжүүлэх бөгөөд сангийн хөрөнгийн үр өгөөжийг одоо ба ирээдүй үеийн иргэддээ хүртээхдээ тэгш байдал, шударга ёсны зарчмыг дээдлэх, сангийн хөрөнгийн удирдлагын компанийн давуу эрхийн хувьцааны ногдол ашиг олгох;

1.1.4.газрын хэвлийн баялаг ашигласны улмаас хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөллийн талаар иргэний мэдэх эрхийг хангах, байгалийн тэнцлийг хадгалах.



Д/д	Хуулийн нэр	Хугацаа	Хуулийн төслийн зохицуулах харилцааны товч утга
1.	Ашигт малтмалын тухай болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2020 он	<ul style="list-style-type: none">• Нөөц ашигласны төлбөр, бусад төрлийн татварын зохицуулалтыг боловсронгуй болгох;• Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын талаарх зохицуулалтыг боловсронгуй болгох;• Засгийн газар байгалийн баялгийг ашиглах шийдвэр гаргах зарчим, журмыг боловсронгуй болгох;• Онцгой ач холбогдол бүхий зарим асуудлаар иргэдтэй зөвлөлдөх, тэдгээрийн саналыг авч тусгах механизмыг тодорхой болгож, уялдаа холбоо нь хангах;• Ашигт малтмал хайх, олборлох, ашиглах явцад байгалийн тэнцлийг хангах, нөхөн сэргээх, эдгээр үйл ажиллагаанд оролцогчийн үүрэг хариуцлагыг тодорхой болгох.
2.	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2020 он	<ul style="list-style-type: none">• Төрийн нийтийн өмчийн зохицуулалтыг тодорхой болгох.
3.	Байгаль орчны тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2020 он	<ul style="list-style-type: none">• Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар иргэний мэдэх эрхтэй холбогдсон зохицуулалтыг нэмэх.
4.	Цөмийн энергийн тухай болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2020 он	<ul style="list-style-type: none">• Хуулийн зохицуулалтыг Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч байх зарчимд нийцүүлэх;• Гадаад улсын цацраг идэвхт хаягдлыг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх, дамжин өнгөрүүлэх, Монгол Улсын нутаг дэвсгэрт булшлахыг хориглох зохицуулалтыг тусгах.



5.	<p>-Үндэсний баялгийн сангийн тухай /Анхдагч хууль/</p> <p>-Засгийн газрын тусгай сангийн тухай болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай</p>	2020 он	<ul style="list-style-type: none"> Газрын хэвлийн баялаг ашигласны орлогоос Үндэсний баялгийн санд төвлөрүүлж, түүнийг санхүүгийн үр ашиг бүхий төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх, үнэт цаас гаргах зэргээр арвижуулах; Эдийн засгийн хүртээмжтэй өсөлтийг хангах, шударгаар хуваарилах зарчмыг баримтлах; Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн зохицуулалтыг Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нийцүүлэх.
6.	<p>Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай</p>	2020 он	<ul style="list-style-type: none"> Газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар иргэний мэдэх эрхийг баталгаажуулах; Иргэний эрүүл, аюулгүй орчинд амьдрах үндсэн эрхийг зөрчиж байгаа эсэхэд иргэд хөндлөнгийн хяналт тавих эрх зүйн үндсийг тогтоох.
7.	<p>Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай</p>	2020 он	<ul style="list-style-type: none"> Иргэний эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхийн хэрэгжилтэд тавих хяналтыг боловсронгуй болгох.

1.2.Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлого, төсөв, санхүүтэй холбоотой нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан боловсруулах хуулийн төсөлд дараах чиглэл баримтална:

1.2.1.Улсын Их Хурал цаг хугацааны шалгуурыг давах Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлогыг батлахдаа нийгмийн зөвшилцлийг хангаж байх;

1.2.2.хөгжлийн бодлого, төлөвлөлтийн удирдлага, бүтэц, зохион байгуулалтын тогтолцоог үндэсний түвшинд бүрдүүлэх, Засгийн газрын бүтцийн үндсэн нэгжийг байгуулах эрх зүйн үндсийг тогтоох;

1.2.3.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсвийг Улсын Их Хурлаар хэлэлцэн батлахдаа хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцүүлэх эрх зүйн үндсийг тогтоох;

1.2.4.Улсын Их Хурал Засгийн газрын өргөн мэдүүлсэн тухайн жилийн төсвийг хэлэлцэн батлахдаа төсвийн зарлагын болон алдагдлын

хэмжээг нэмэгдүүлэхгүй байх, харин төсвийн орлого, зарлагын бүтцийг хөгжлийн бодлогод нийцүүлэн өөрчилж болохоор зохицуулах;

1.2.5.төрийн санхүү, төсвийн хяналт /аудит/-ыг хараат бусаар хэрэгжүүлэх байгууллагын бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтоох;

1.2.6.төрийн нийтийн өмчийг зохистой ашиглах, зарцуулахад тавих хяналтыг боловсронгуй болгох.

Д/д	Хуулийн нэр	Хугацаа	Хуулийн төслийн зохицуулах харилцааны товч утга
1.	-Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ -Холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2020 он	<ul style="list-style-type: none"> Хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байх, хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн уялдаа холбоог хангах, төлөвлөлтийн байнгын, мэргэшсэн тогтолцоог бүрдүүлэх, бодлого, төлөвлөлт нь дээрээсээ доош, доороосоо дээш чиглэх зарчмыг тодорхойлж, цаг хугацааны болон нутаг дэвсгэрийн онцлогоос шалтгаалсан орон зайн төлөвлөлт хийх механизмыг бүрдүүлэх; Хөгжлийн бодлого, төлөвлөлт нь судалгаанд үндэслэсэн байх бөгөөд түүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх байнгын тогтвортой тогтолцоог бүрдүүлэх; Хөгжлийн бодлого, төлөвлөлт хариуцсан Засгийн газрын үндсэн бүтцийн нэгж, байгуулах бөгөөд улс төрийн сонгуулийн мөчлөгөөс үл хамааран тогтвортой ажиллах зохицуулалтыг бий болгох; Бодлого боловсруулах, төлөвлөлт хийх хүний нөөцийн чадавхад суурилсан онцлог тогтолцоог бүрдүүлэх.
2.	Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2020 он	<ul style="list-style-type: none"> Улсын Их Хурал Засгийн газрын өргөн мэдүүлсэн төсвийг хэлэлцэн батлахдаа төсвийн зарлагын болон алдагдлын хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцүүлэн улсын төсвийн орлого, зарлагын бүтцийг өөрчилж болох зохицуулалтыг тусгах;



			<ul style="list-style-type: none"> • Жил бүрийн улсын төсөв нь урт болон дунд хугацааны хөгжлийн бодлого, эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлд суурилсан байх шаардлагыг хуульчлах; • Улсын Их Хурлаас төсвийн хэрэгжилтэд хяналт тавих тогтолцоог боловсронгуй болгох.
3.	<p>-Улс төрийн намын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай</p> <p>- Холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай</p>	2020 он	<ul style="list-style-type: none"> • Сонгуульд өрсөлдөх улс төрийн намын мөрийн хөтөлбөрийн зорилт нь хөгжлийн урт хугацааны бодлого, төлөвлөлтөд нийцсэн байх шаардлагыг тусгах; • Дээрх шаардлага хангагдаагүйгээс үүсэх хууль зүйн үр дагаврыг хуульчлах.
4.	Төрийн аудитын тухай хууль /Шинэчилсэн найруулга/	2020 он	<ul style="list-style-type: none"> • Төрийн аудитын байгууллагын бие даасан, үйл ажиллагааны хараат бус байдлыг сайжруулах, эрх хэмжээг нэмэгдүүлэх; • Зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн шинэчлэх.

1.3.Улсын Их Хурлын үйл ажиллагааг боловсронгуй болгож, хариуцлагыг сайжруулах нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан боловсруулах хуулийн төсөлд дараах чиглэл баримтална:

1.3.1.Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татахад Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөнийг Үндсэн хуулийн цэц тогтоосон байхыг үндэслэл болгох;

1.3.2.Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин хоёрдугаар зүйлд орсон нэмэлт, өөрчлөлтийн дагуу Улсын Их Хурлын бүрэн эрх хугацаанаасаа өмнө дуусгавар болох зохицуулалтыг боловсронгуй болгох;

1.3.3.Монгол Улсын Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар асуудлыг шийдвэрлэх, хуулийг Улсын Их Хурлын нийт гишүүний олонхын саналаар эцэслэн батлах, Улсын Их Хурлын гишүүд саналаа илээр гаргадаг үндсэн зарчмыг хадгалж, харин Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуульд заасан, эсхүл хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол нууц санал хураалт явуулж байхаар өөрчлөх;

1.3.4.Хянан шалгах түр хороог хуулиар тусгайлан тогтоосон эрх хэмжээний хүрээнд мэргэжлийн хараат бус шинжээч томилох, гэрч,

шинжээчээс мэдүүлэг авах, нотлох баримт гаргуулах зэрэг арга хэрэгсэл ашиглан Засгийн газар, түүний байгууллага, албан тушаалтан хууль зөрчсөн эсэх, эрх мэдлээ урвуулан ашигласан эсэх, төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулсан эсэх болон нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар дүгнэлт гаргах, иргэдэд үнэн зөв, бодитой мэдээлэл хүргэх зорилгоор байгуулах, түр хорооноос гаргасан дүгнэлт шүүхэд үүрэг хүлээлгэхгүй байх зарчмыг хуульчлах;

1.3.5.Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын хууль санаачлах эрхийн хүрээ, хязгаарыг хуулиар тогтоох;

1.3.6.Улсын Их Хурлын хууль тогтоомжийн төсөл хэлэлцэн батлах үйл ажиллагааны болон батлах хууль тогтоомжийн чанарыг сайжруулах, түүнчлэн хянан шалгах бүрэн эрхийг үр нөлөөтэй хэрэгжүүлэх зорилгоор Улсын Их Хурлын ээлжит чуулганы үргэлжлэх хугацааг 75-аас доошгүй ажлын өдөр болгон нэмэгдүүлэх;

1.3.7.Монгол Улс өөрийн тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг үгүйсгэхтэй холбоотой аливаа санал асуулга явуулахыг хориглох эрх зүйн үндсийг тогтоох;

1.3.8.Улсын Их Хурлын ээлжит сонгууль явуулахын өмнөх нэг жилийн дотор Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглох.

Д/д	Хуулийн нэр	Хугацаа	Хуулийн төслийн зохицуулах харилцааны товч утга
1.	Монгол Улсын Их Хурлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/	2020 оны хаврын ээлжит чуулган	<ul style="list-style-type: none"> Ээлжит чуулганы үргэлжлэх хугацааг 75-аас доошгүй ажлын өдөр болгон нэмэгдүүлсэнтэй холбогдуулан ээлжит чуулганы нээх, хаах хугацааг зохицуулах; Улсын Их Хурлын Байнгын хороо, нэгдсэн хуралдаанаар асуудлыг шийдвэрлэх санал хураалтын зарчмыг тодорхойлох; Улсын Их Хурлын бүрэн эрх хугацаанаасаа өмнө дуусгавар болохтой холбогдсон зохицуулалтыг тодотгох; Улсын Их Хурлын Хянан шалгах түр хороо байгуулахтай холбогдсон зохицуулалтыг хуульчлах.



2.	Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/	2020 оны хаврын ээлжит чуулган	<ul style="list-style-type: none"> • Хууль хэлэлцэх, эцэслэн батлах журмыг тогтоох; • Улсын Их Хурлын хуралдааны санал хураалтын зарчим, журмыг тогтоох; • Хянан шалгах түр хорооны хуралдааны дэгийг нарийвчлан зохицуулах; • Улсын Их Хурлаар улсын төсвийг хэлэлцэн батлах дэгийг боловсронгуй болгох; • Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татах асуудлыг хэлэлцэх журмыг тогтоох; • Ерөнхий сайдад нэр дэвшүүлж, томилох, огцруулах, чөлөөлөх, түүнд итгэл хүлээлгэх эсэхийг хэлэлцэх дэгийг боловсронгуй болгох; • Ерөнхий сайд Засгийн газрын гишүүнийг Улсын Их Хуралд танилцуулах журмыг тогтоох; • Засгийн газрын гишүүн Улсын Их Хуралд тангараг өргөх журмыг тогтоох.
3.	Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2020 он	<ul style="list-style-type: none"> • Хууль санаачлах эрхийн хүрээ, хязгаартай холбогдуулан нэмэлт, өөрчлөлт оруулах.
4.	Ард нийтийн санал асуулгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2020 он	<ul style="list-style-type: none"> • Тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг үгүйсгэх зорилго бүхий ард нийтийн санал асуулга явуулахыг хориглосон зохицуулалт оруулах.

1.4.Улс төрийн намтай холбоотой нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан боловсруулах хуулийн төсөлд дараах чиглэл баримтална:

1.4.1.Монгол Улс төрийн байгууламжийн хувьд нэгдмэл байх зарчмыг хангах үүднээс нам улсын хэмжээний бодлого дэвшүүлэн ажиллах, баримталж буй бодлого нь улсын хэмжээний асуудлыг хамарсан байх шаардлагыг хуульчлах;

1.4.2.намын үйл ажиллагаа, дүрэм нь хуульд нийцсэн байх, намын дотоодод шийдвэр гаргах, хэлэлцэх үйл явц нь ил тод, гишүүддээ

нээлттэй байх, намын дотоод зохион байгуулалт ардчилсан зарчимд нийцсэн байх гол шалгуурыг хуульчлах;

1.4.3.Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэдийн нэг хувиас доошгүй тооны дэмжлэг авсны үндсэн дээр улс төрийн нам байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх;

1.4.4.намын санхүүжилтийн эх үүсвэр, түүний зарцуулалт, тайлан нь олон нийтэд ил тод байх эрх зүйн орчныг бүрдүүлэх;

1.4.5.төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх нөхцөлийг тогтоох.

Д/д	Хуулийн нэр	Хугацаа	Хуулийн төслийн зохицуулах харилцааны товч утга
1.	-Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ -Улс төрийн намын санхүүжилтийн тухай хууль /Анхдагч хууль/	2020 он	<ul style="list-style-type: none"> • Намын чиг үүрэг, санхүүжилт, үйл ажиллагаа хууль дээдлэх зарчимд суурилсан байх; • Улс төрийн намын хариуцлагын тогтолцоог тодорхой болгох; • Улс төрийн намын хөрөнгө, орлогын эх үүсвэр, зарцуулалт нийтэд ил тод байх; • Төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх нөхцөлийг тогтоох; • Сонгуулийн эрх бүхий иргэдийн нэг хувиас доошгүй тооны иргэний дэмжлэг авсны үндсэн дээр улс төрийн нам байгуулах журмыг тогтоох.

ХОЁР.ГҮЙЦЭТГЭХ ЭРХ МЭДЭЛТЭЙ ХОЛБООТОЙ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ

2.1.Засгийн газрыг эмхлэн байгуулах нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан боловсруулах хуулийн төсөлд дараах чиглэл баримтална:

2.1.1.сонгуулийн дүнгээр аль ч нам, эвсэл олонхын суудал аваагүй тохиолдолд улс төрийн нам, эвсэл заавал олонхыг бүрдүүлж Ерөнхий сайдад нэр дэвшүүлэх шаардлагыг хуульчлах;

2.1.2.Ерөнхий сайд Засгийн газрын бүтцийн тухай болон Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн төслийг Ерөнхийлөгчтэй



зөвшилцөн Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, зөвшилцөж чадаагүй тохиолдолд өөрөө өргөн мэдүүлэх зохицуулалтыг хуульчлах;

2.1.3.Ерөнхий сайд болон Засгийн газрын гишүүдийн дөрвөөс илүүгүй нь Улсын Их Хурлын гишүүн байж болох зохицуулалтыг холбогдох хуульд тусгах;

2.1.4.Засгийн газрын гишүүн Улсын Их Хуралд тангараг өргөх журмыг тогтоох.

2.2.Засгийн газар танхимын зарчмаар, тогтвортой ажиллахтай холбоотой нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан боловсруулах хуулийн төсөлд дараах чиглэл баримтална:

2.2.1.Ерөнхий сайд Улсын Их Хурал, Ерөнхийлөгчид танилцуулсны үндсэн дээр Засгийн газрын гишүүнийг томилох, чөлөөлөх, огцруулах зохицуулалтыг хуульчлах;

2.2.2.Ерөнхий сайдыг огцруулах, Ерөнхий сайд огцорвол Засгийн газар бүрэлдэхүүнээрээ огцрох талаар Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хуульд тусгах;

2.2.3.Ерөнхий сайдад итгэл үзүүлэх эсэх асуудлаар Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хуульд тусгах.

Д/д	Хуулийн нэр	Хугацаа	Хуулийн төслийн зохицуулах харилцааны товч утга
1.	Монгол Улсын Засгийн газрын тухай хууль /Шинэчилсэн найруулга/	2020 оны хаврын ээлжит чуулган	<ul style="list-style-type: none"> • Засгийн газрын тогтвортой ажиллах эрх зүйн үндсийг боловсронгуй болгох; • Засгийн газар танхимаар ажиллах зарчимд нийцүүлэн Ерөнхий сайд бие даан танхимаа бүрдүүлэх зохицуулалтыг хуульчлах; • Ерөнхий сайд өөрт нь итгэл үзүүлэх эсэх асуудлыг Улсын Их Хуралд оруулах зохицуулалтыг хуульчлах; • Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүнээр хавсран ажиллах хязгаарыг хуульчлах.

2.3.Ерөнхийлөгчид нэр дэвших насны босго, бүрэн эрхийн хугацааг нэмэх талаарх нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан боловсруулах хуулийн төсөлд дараах чиглэл баримтална:

2.3.1.Монгол Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдох насны доод хязгаарыг өндөрсгөж, зөвхөн нэг удаа сонгогдох;

2.3.2.Монгол Улсын Ерөнхийлөгчид зөвхөн Монгол Улсын Үндсэн хуульд заасан үндсэн бүрэн эрхийнх нь хүрээнд тодорхой бүрэн эрх олгож байхаар зохицуулах.

Д/д	Хуулийн нэр	Хугацаа	Хуулийн төслийн зохицуулах харилцааны товч утга
1.	-Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ -Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ -Холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2020 он	<ul style="list-style-type: none"> • Ерөнхийлөгчид нэр дэвшигчид тавих шаардлага, бүрэн эрхийн хугацаатай холбоотой зохицуулалтыг Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэх; • Ерөнхийлөгчид хуулиар олгосон бүрэн эрх Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлд заасан хүрээнд байх нэмэлт, өөрчлөлтийг холбогдох хууль тогтоомжид оруулах; • Ерөнхийлөгчид тодорхой бүрэн эрх олгох асуудлыг Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэх.

**ГУРАВ.ШҮҮХИЙН ХАРААТ БУС БАЙДЛЫГ ХАНГАЖ,
ШҮҮГЧИЙН ХАРИУЦЛАГЫГ ДЭЭШЛҮҮЛЭХТЭЙ
ХОЛБООТОЙ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ**

3.1.Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах талаарх нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан боловсруулах хуулийн төсөлд дараах чиглэл баримтална:

3.1.1.Шүүхийн ерөнхий зөвлөлийн бие даасан, хараат бус, тогтвортой байдлыг хангах зорилгоор түүний бүрэлдэхүүний тавыг шүүгчид дотроосоо хувь тэнцүүлэн сонгож, бусад таван гишүүнийг бусад институцээс тэнцвэртэй оролцооны үндсэн дээр нээлттэй нэр дэвшүүлэн, сонгон шалгаруулж томилох, гишүүдийг зөвхөн нэгэн бүрэн эрхийн хугацаанд ажиллуулах, Зөвлөлийн даргыг гишүүд дотроосоо сонгох журмыг хуулиар тогтоох;

3.1.2.шүүгчийн хараат бус байдлыг хангахтай холбоотой Шүүхийн ерөнхий зөвлөлийн үйл ажиллагааны тайланг Улсын дээд шүүхэд танилцуулах зохицуулалтыг хуульчлах.



Д/д	Хуулийн нэр	Хугацаа	Хуулийн төслийн зохицуулах харилцааны товч утга
1.	-Шүүхийн захиргааны тухай хууль /Шинэчилсэн найруулга/ -Холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2 0 2 0 он	<ul style="list-style-type: none"> • Шүүхийн ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүн, гишүүнд тавих болзол, шалгуур, тэдгээрийг сонгох, томилох, Зөвлөлийн даргыг сонгох журам; • Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах чиг үүргийг тодорхойлох; • Шүүгчийн хараат бус байдлыг хангахтай холбоотой Шүүхийн ерөнхий зөвлөлийн үйл ажиллагааны тайланг Улсын дээд шүүхэд танилцуулах журам.

3.2.Шүүгчийн хариуцлагыг сайжруулах талаарх нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан боловсруулах хуулийн төсөлд дараах чиглэл баримтална:

3.2.1.хуульд заасан үндэслэл, журмын дагуу шүүгчид сахилгын шийтгэл ногдуулах чиг үүрэг бүхий Шүүхийн сахилгын хороог байгуулах, түүний чиг үүрэг, үйл ажиллагааны зарчим, журмыг хуулиар тогтоох;

3.2.2.Шүүхийн сахилгын хороо нь хөндлөнгийн нөлөөллөөс ангид байж, төвийг сахиж хараат бусаар шийдвэр гаргаж, шүүгчийг сахилгын шийтгэлийн журмаар албан тушаалаас нь түдгэлзүүлэх, огцруулах, сахилгын бусад шийтгэл ногдуулах замаар шүүгчийн ёс зүй, шүүхэд итгэх иргэдийн итгэлийг дээшлүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх;

3.2.3.Шүүхийн сахилгын хорооны гишүүдийг шүүн таслах ажлын туршлагатай хуульчид, нэр хүндтэй иргэд, хууль зүйн өндөр мэргэшилтэй эрдэмтдээс нээлттэй нэр дэвшүүлэх замаар холбогдох институтээс тэнцвэртэйгээр бүрдүүлэх зарчмыг хуульчлах.

Д/д	Хуулийн нэр	Хугацаа	Хуулийн төслийн зохицуулах харилцааны товч утга
1.	- Шүүхийн сахилгын хорооны тухай хууль /Анхдагч хууль/ - Шүүгчийн эрх зүйн байдлын тухай болон Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2020 он	<ul style="list-style-type: none"> • Шүүхийн сахилгын хорооны бүрэлдэхүүн, гишүүнд тавих болзол, шалгуур, бүрдүүлж байгуулах журмыг тогтоох; • Шүүгчид хариуцлага хүлээлгэх журмыг хариуцлага зайлшгүй байх, зөрчлийн шинж байдалдаа тохирсон байх, давхардахгүй байх зарчмыг үндэслэн тодорхойлох; • Хорооны бүрэн эрх, үйл ажиллагааны болон сахилгын

			<p>зөрчил хянан шийдвэрлэх журмыг хуульчлах;</p> <ul style="list-style-type: none"> • Хорооны шийдвэрийн хууль зүйн үндэслэлийг гомдлын дагуу Улсын дээд шүүх эцэслэн хянах журмыг тогтоох.
--	--	--	--

3.3.Шүүхийг тойргийн зарчмаар байгуулах талаарх нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан боловсруулах хуулийн төсөлд дараах чиглэл баримтална:

3.3.1.шүүхийг тойргийн зарчмаар байгуулахдаа иргэний шүүхэд хандах эрхийн баталгааг бодитой хангах, шүүгчийн ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, шүүгчийг мэргэшүүлэх, шүүхийн үйлчилгээг иргэдэд ойртуулж хүртээмжтэй болгох үндсэн зарчимд нийцүүлнэ.

Д/д	Хуулийн нэр	Хугацаа	Хуулийн төслийн зохицуулах харилцааны товч утга
1.	Шүүх байгуулах тухай болон Шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2021 он	<ul style="list-style-type: none"> • Хүн ам, газар нутаг, шүүгчийн ажлын ачааллыг харгалзан тойргийн шүүх байгуулж болох үндэслэл, журмыг нарийвчлан тогтоох; • Шүүхийн бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдөх, тойргийн зарчмаар шүүх байгуулах нь шүүгчийг өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр чөлөөлөх, шилжүүлэх үндэслэл болохгүй байх зохицуулалтыг хуульчлах.

**ДӨРӨВ.НУТГИЙН УДИРДЛАГАТАЙ ХОЛБООТОЙ
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ**

4.1.Хот, тосгоны эрх зүйн байдлыг тодорхой болгох нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан боловсруулах хуулийн төсөлд дараах чиглэл баримтална:

4.1.1.улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, түүнчлэн тосгоны эрх зүйн үндэс, тэдгээрийн өөрийн удирдлагын болон засаг захиргааны зохион байгуулалтын зарчмыг хуулиар тогтоож, хот, тосгоны өөрийн удирдлагыг оршин суугчид нь сонгож, хот, тосгоны удирдлагад засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын болон төсөв, санхүүгийн зарим эрх мэдлийг шилжүүлэх, удирдлагын давхардал, хийдлийг арилгах, хотын нийтийн үйлчилгээг оршин суугчдад, төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулах, эдийн засгийн хувьд хот, тосгон харьцангуй бие даан хөгжих боломжийг бүрдүүлэх.



4.2.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан боловсруулах хуулийн төсөлд дараах чиглэл баримтална:

4.2.1.засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлыг тухайн нутгийн иргэдийн саналд үндэслэн шийдвэрлэх зарчмыг хэвээр хадгалж, уг асуудлыг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх үүргийг Засгийн газар хүлээх.

4.3.Нутгийн өөрөө удирдах ёсны эрх зүйн үндсийг тогтоох нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан боловсруулах хуулийн төсөлд дараах чиглэл баримтална:

4.3.1.аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны чөлөө цагт тухайн Хурлын Тэргүүлэгчид нь Хурлын бүрэн эрхийг хэрэгжүүлж ирсэн тогтолцоог халж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь шаардлагатай тохиолдолд хуралдаж асуудлаа шийдвэрлэж байх;

4.3.2.аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд өмчийн удирдлагыг хэрэгжүүлэх, татварын хувь хэмжээг тогтоож байхаар зааж, тэдгээрийн чиг үүрэг, төсвийн харилцааны үндсийг тухайн нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн амьдралын тодорхой онцлогт нийцүүлэн хуулиар тогтоох эрх зүйн үндсийг бүрдүүлэх;

4.3.3.аймаг, нийслэл, сум, дүүргийн эрх зүйн байдал, өмчийн болон төсвийн харилцааг тусгайлсан хуулиар ялгамжтай зохицуулах, аймаг, нийслэл, сум, дүүрэг бие даан хөгжих боломжийг бүрдүүлэх зорилгоор татварын хуваарилалтын зарчмыг шинэчлэх, орон нутагт ногдох татварын суурийг өргөтгөх;

4.3.4.шинэчлэн боловсруулсан Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулиудад салбарын бусад хууль тогтоомжийг нийцүүлэх.

Д/д	Хуулийн нэр	Хугацаа	Хуулийн төслийн зохицуулах харилцааны товч утга
1.	-Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ -Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль / Шинэчилсэн найруулга/	2020 он	<ul style="list-style-type: none"> • Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд өмчийн удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбогдсон зохицуулалтыг хуульчлах; • Татварын хувь хэмжээг тогтооходой холбогдсон зохицуулалтыг хуульчлах;



<p>-Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/</p> <p>-Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай</p> <p>-Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай</p> <p>-Татварын ерөнхий хууль болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай</p>	<ul style="list-style-type: none"> • Төсвийн харилцааны үндсийг тухайн нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн амьдралын тодорхой онцлогт нийцүүлэн тогтоохтой холбогдсон зохицуулалтыг хуульчлах; • Хот, тосгоны эрх зүйн үндсийг тодорхой болгож, тэдгээрийн өөрийн удирдлага, өмчийн болон төсвийн зохицуулалтыг нарийвчлан тусгах; • Хот, тосгонд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын зарим чиг үүргийг шилжүүлэх асуудлыг зохицуулах.
--	---

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хууль баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т даалгасугай:

1/төрийн өмчит “Эрдэнэс Монгол” ХХК-ийн үйл ажиллагааг сайжруулах замаар орлогыг нэмэгдүүлэх арга хэмжээг авах, шаардлагатай тохиолдолд “Эрдэнэс силвер ресурс” ХХК-ийн аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн асуудлыг судалж, саналаа холбогдох хууль тогтоомжийн өөрчлөлтийн хамт Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;



2/төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх, нийгмийн даатгалын багц хуулийн төслийг Монгол Улсын Их Хуралд 2020 оны 01 дүгээр улиралд багтаан өргөн мэдүүлэх.

2.Энэ тогтоолыг Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 01 дүгээр
сарын 10-ны өдөр

Дугаар 05

Улаанбаатар
хот

Хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Засгийн газраас 2020 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Иргэдийн тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Ахмад настны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх тухайн асуудлаар хууль гаргах шаардлагагүй гэж үзсэн тул хууль санаачлагчид нь буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

САНХҮҮГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР

2016-2017 он

Төвийн бүсийн цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний
үр ашгийг дээшлүүлэх II

Монгол Улсын Засгийн газар,
Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Засгийн газар-

Монгол Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын хооронд
тогтсон найрсаг харилцааны үзэл санаанд тулгуурлан,

энэхүү найрсаг харилцааг түншилсэн Санхүүгийн хамтын
ажиллагаагаар бэхжүүлэн, гүнзгийрүүлэхийг эрмэлзэж,

уг харилцааг хэвээр хадгалах нь энэхүү Хэлэлцээрийн үндсийг
бүрдүүлнэ гэдгийг ухамсарлан,

Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд байгаль орчны
тогтвортой байдалд тулгуурлан хувь нэмэр оруулах зорилгоор,

хоёр орны Засгийн газар хоорондын 2016 оны 11 дүгээр сарын 25-
ны өдрийн хэлэлцээний протоколыг үндэслэн-

дараах зүйлийг хэлэлцэн тохиролцов.

1 ДҮГЭЭР ЗҮЙЛ

(1) Хэрэв дэмжлэг үзүүлэх нь зүйтэй гэж судалгааны дүнд тогтоовол
Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Засгийн газар нь Монгол Улсын
Засгийн газарт “Төвийн бүсийн цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний үр
ашгийг дээшлүүлэх II” төсөлд 10 450 000 (үсгээр: арван сая дөрвөн зуун
тавин мянга) хүртэлх еврогийн зээлийг Сэргээн босголтын зээлийн банк
(KfW)-наас авах боломж олгоно.



(2) Монгол Улсын Засгийн газар, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Засгийн газар харилцан тохиролцооноор 1 дэх заалтад дурдсан төслийг өөр төслүүдээр орлуулж болно.

(3) Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Засгийн газар нь 1 дэх заалтад дурдсан төслийн бэлтгэл ажлыг хангахад зориулан нэмэлт зээл эсвэл санхүүгийн хөрөнгө, эсхүл 1 дэх заалтад дурдсан төслийг хэрэгжүүлэх, дэмжихэд шаардагдах дагалдах арга хэмжээнд зориулан нэмэлт санхүүгийн хөрөнгө Сэргээн босголтын зээлийн банкнаас авах боломжийг Монгол Улсын Засгийн газарт хожим олгох тохиолдолд энэхүү Хэлэлцээр нэгэн адил хүчин төгөлдөр үйлчилнэ.

2 ДУГААР ЗҮЙЛ

(1) Энэхүү Хэлэлцээрийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтад дурдсан хөрөнгийг ашиглах, олгох нөхцөл болон ажил гүйцэтгүүлэх журам зэргийг Сэргээн босголтын зээлийн банк, зээл хүлээн авагчийн хооронд байгуулах, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад хууль тогтоомжийг мөрдлөг болгох гэрээгээр зохицуулна.

(2) Энэхүү Хэлэлцээрийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтад дурдсан хөрөнгийг олгох амлалт өгснөөс хойш зургаан жилийн дотор холбогдох зээлийн гэрээнүүд байгуулагдаагүй тохиолдолд уг амлалт хүчингүй болно. Дээрх заалтад дурдсан хөрөнгийн хувьд 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр уг хугацаа дуусгавар болно.

(3) Монгол Улсын Засгийн газар нь зээл хүлээн авагч биш байх тохиолдолд энэ зүйлийн 1 дэх заалтын дагуу байгуулах гэрээг үндэслэн зээл хүлээн авагчийн бүх төлбөрийг еврогоор буцаан төлөх баталгааг Сэргээн босголтын зээлийн банкинд гаргана.

3 ДУГААР ЗҮЙЛ

Монгол Улсын Засгийн газар нь энэхүү Хэлэлцээрийн 2 дугаар зүйлийн 1 дэх заалтад дурдсан гэрээнүүдийг байгуулах, хэрэгжүүлэхтэй холбогдон ногдуулж болох Монгол Улсын шууд татвар, хураамжаас Сэргээн босголтын зээлийн банкиг чөлөөлнө. Дээр дурдсантай холбогдуулан ногдуулсан нэмэгдсэн өртгийн албан татвар болон бусад адил төрлийн шууд бус татвар, ноогдуулсан онцгой албан татварыг Монгол Улсын Засгийн газар хариуцна. Түүнчлэн Монгол Улсын Засгийн газар нь бусад албан татвар, хураамжаас Сэргээн босголтын зээлийн банкиг чөлөөлнө.

4 ДҮГЭЭР ЗҮЙЛ

Монгол Улсын Засгийн газар нь зээл олгосонтой холбоотойгоор зорчигч болон ханган нийлүүлэгчдийг хуурай болон усан зам, агаараар хүн болон бараа тээвэрлэх тээврийн байгууллагыг чөлөөтэй сонгох боломжоор ханган, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад байрладаг тээврийн байгууллагуудыг үүнд тэгш эрхтэй оролцоход саад тотгор болох, эсхүл хязгаарлах аливаа арга хэмжээг авахаас түдгэлзэн, шаардлагатай нөхцөлд тэдэнд зохих зөвшөөрлийг олгоно.

5 ДУГААР ЗҮЙЛ

(1) Энэхүү Хэлэлцээр нь түүнийг хүчин төгөлдөр болгох дотоодын хууль тогтоомжийн шаардлагыг хангасан тухай мэдэгдлийг Монгол Улсын Засгийн газраас Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Засгийн газарт хүргүүлсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно. Энэхүү Хэлэлцээрийн хүчин төгөлдөр болох өдөр нь дээрх мэдэгдлийг хүлээн авсан өдөр байна.

(2) Энэхүү Хэлэлцээрийг хүчин төгөлдөр болмогц Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Засгийн газар Нэгдсэн Үндэстний Байгууллагын Нарийн бичгийн дарга нарын газарт Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмийн 102 дугаар зүйлд заасны дагуу бүртгүүлнэ. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Нарийн бичгийн дарга нарын газар бүртгэж авснаа баталгаажуулмагц хэлэлцэн тохиролцогч нөгөө талд Хэлэлцээрийг бүртгүүлсэн тухай НҮБ-ын бүртгэлийн дугаарыг заан мэдээлнэ.

(3) Хэлэлцэн тохиролцогч Талууд энэхүү Хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах талаар тохиролцож болно.

(4) Энэхүү Хэлэлцээрийг тайлбарлах, хэрэглэхэд үүсэх маргааныг хэлэлцэн тохиролцогч Талууд яриа, хэлэлцээний замаар эв зүйгээр шийдвэрлэнэ.

Энэхүү Хэлэлцээрийг Улаанбаатар хотноо 2018 оны 06 дугаар сарын 22-ны өдөр монгол, англи, герман хэл дээр тус бүр хоёр эх хувь байгуулсан бөгөөд эх хувь бүр нь адил хүчинтэй байна. Герман, монгол хэл дээрх эх бичвэрийг тайлбарлахад зөрүү гарвал англи хэл дээрх эх бичвэрийг баримтална.

Монгол Улсын
Засгийн газрыг төлөөлж



Холбооны Бүгд Найрамдах Герман
Улсын Засгийн газрыг төлөөлж





МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

ЗЭЭЛИЙН БОЛОН ТӨСЛИЙН ГЭРЭЭ

МОНГОЛ УЛСЫГ ТӨЛӨӨЛЖ САНГИЙН ЯАМ
("Зээлдэгч"), болон

ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ ТӨХК
("Төсөл хэрэгжүүлэгч байгууллага") болон

ФРАНКФУРТ ХОТ ДАХЬ СЭРГЭЭН БОСГОЛТ ЗЭЭЛИЙН БАНК
("СБЗБ"),

хоорондын

2018 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн

20,450,000.00 ЕВРОГИИН

ЗЭЭЛИЙН БОЛОН ТӨСЛИЙН ГЭРЭЭ

**"ТӨВИЙН БҮСИЙН ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ,
ТҮГЭЭХ СҮЛЖЭЭНИЙ ҮР АШГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТӨСӨЛ"**

(BMZ-No.: 201465129 ба 201665009)

Монгол Улсын Засгийн газар, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Засгийн газар хоорондын 2015 оны 10 дугаар сарын 19-ний болон 2018 оны 6 дугаар сарын 22-ны өдөр байгуулсан Санхүүгийн хамтын ажиллагаа хэлэлцээр ("Засгийн газар хоорондын хэлэлцээр")-ийг үндэслэн Зээлдэгч, Төсөл хэрэгжүүлэгч байгууллага болон Сэргээн босголт зээлийн банк (СБЗБ)-ны хооронд дараах Зээлийн болон төслийн гэрээг байгуулав:

Нэгдүгээр зүйл

Зээлийн хэмжээ ба зориулалт

- 1.1. СБЗБ нь Зээлдэгчид 20,450,000.00 еврогоос илүүгүй хэмжээний зээлийг олгоно. Зээлийн хэмжээг дараах байдлаар 2 хэсэгт хувааж олгоно.
 - I хэсэг 10,000,000.00 еврогоос илүүгүй хэмжээний зээлийг олгоно. (BMZ-No.:201465129, "I хэсэг");
 - II хэсэг 10,450,000.00 еврогоос илүүгүй хэмжээний зээлийг олгоно. (BMZ-No.:201665009, "II хэсэг");
- 1.2. Зээлдэгч нь зээлийн нийт хөрөнгийг 2 дугаар зүйлд заасан нөхцөлийн дагуу Төсөл хэрэгжүүлэгч байгууллагад дамжуулан зээлдүүлнэ. Төсөл хэрэгжүүлэгч байгууллага нь зээлийн хөрөнгийг зөвхөн Монгол Улсын Төвийн бүсийн эрчим хүчний системийн

дэд станцуудын шинэчлэл, ялангуяа барилгын ажил, тоног төхөөрөмж угсралт, суурилуулалт, олон улсын зөвлөх үйлчилгээ (“Төсөл”), гадаад валютын зардлын төлбөрт голчилж хэрэглэнэ. Төсөл хэрэгжүүлэгч байгууллага болон СБЗБ нь төслийг нарийвчлан тодорхойлж, зээлийн хөрөнгөөр санхүүжигдэх бараа, ажил, үйлчилгээг тусгайлсан гэрээ (“Тусгайлсан гэрээ”)-ээр тохиролцоно.

- 1.3. Зээлдэгч болон Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын хариуцах аливаа татвар, бусад хураамж ба импортын татварыг зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэхгүй.

Хоёрдугаар зүйл

Төсөл хэрэгжүүлэгч байгууллагад дамжуулан зээлдүүлэх

- 2.1. Зээлдэгч нь зээлийн хөрөнгийг Төсөл хэрэгжүүлэгч байгууллагад Монгол Улсын холбогдох журамд заасан нөхцөл, шаардлагын дагуу дамжуулан зээлдүүлэх гэрээний үндсэн дээр олгоно.
- 2.2. Зээлийн эхний төлбөр хийгдэхээс өмнө Зээлдэгч нь 2.1 дэх заалтад заасан дамжуулан зээлдүүлэх гэрээний баталгаажуулсан орчуулгыг СБЗБ-нд хүргүүлсэн байна.
- 2.3. Энэхүү Гэрээний дагуу зээлийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлснээр Төсөл хэрэгжүүлэгч байгууллага болон СБЗБ хооронд ямарваа нэгэн төлбөрийн үүрэг, хариуцлага үүсэхгүй.

Гуравдугаар зүйл

Зээлийн санхүүжилт олгох

- 3.1. СБЗБ нь төслийн явц болон Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын зээлийн хүсэлтийн дагуу зээлийн санхүүжилтийг олгоно. Төсөл хэрэгжүүлэгч байгууллага, СБЗБ хоорондын Тусгайлсан гэрээгээр зээлийн санхүүжилт олгох журам, ялангуяа хүсэлт гаргасан зээлийн дүнг тохиролцсон зориулалтад ашиглагдсаныг нотлох баримт бүрдүүлэх талаар тохиролцоно.
- 3.2. СБЗБ нь 2023 оны 12 дугаар сарын 30-ны өдрөөс хойш зээлийн санхүүжилт олгохоос татгалзах эрхтэй.

Дөрөвдүгээр зүйл

Хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны хураамж, зээлийн хүү, эргэн төлөлт

- 4.1. Зээлдэгч нь ашиглагдаагүй зээлийн хэмжээнд жилийн 0,25 хувийн хүү хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны хураамжид төлнө. Хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны хураамжийг энэхүү зээлийн



- 4.2. гэрээнд гарын үсэг зурсанаас хойш гурван сарын дараагаас эхлэн тооцох ба зээлийг бүрэн олгосон өдрөөр дуусгавар болно. Зээлдэгч нь жилийн 2 хувийн зээлийн хүү төлнө. Хүүг зээлийн хөрөнгийн санхүүжилт эхэлсэн өдрөөс эхлэн тооцож, энэхүү зүйлийн 4.9-д заасан СБЗБ-ны дансанд эргүүлэн төлөх хүртэлх хугацаанд бодож төлнө.
- 4.3. Зээлдэгч нь хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны хураамж, зээлийн хүү болон энэхүү зүйлийн 4.5-д заасан хугацаа хэтэрсний аливаа хураамжийг хагас жил тутам, жил бүрийн 6 дугаар сарын 30-ны өдөр, 12 дугаар сарын 30-ны өдөр төлнө. Хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны эхний хураамжийг анхны хүүгийн төлбөртэй хамт төлнө.
- 4.4. Зээлдэгч нь зээлийг дараах байдлаар эргүүлэн төлнө.

Д/д	Зээл төлөх хугацаа		I хэсэг	II хэсэг	Нийт	Зээлийн төлбөр (Евро)
1	12-р сарын 30,	2028	250,000.00	261,000.00	511,000.00	EUR
2	6-р сарын 30,	2029	250,000.00	261,000.00	511,000.00	EUR
3	12-р сарын 30,	2029	250,000.00	261,000.00	511,000.00	EUR
4	6-р сарын 30,	2030	250,000.00	261,000.00	511,000.00	EUR
5	12-р сарын 30,	2030	250,000.00	261,000.00	511,000.00	EUR
6	6-р сарын 30,	2031	250,000.00	261,000.00	511,000.00	EUR
7	12-р сарын 30,	2031	250,000.00	261,000.00	511,000.00	EUR
8	6-р сарын 30,	2032	250,000.00	261,000.00	511,000.00	EUR
9	12-р сарын 30,	2032	250,000.00	261,000.00	511,000.00	EUR
10	6-р сарын 30,	2033	250,000.00	261,000.00	511,000.00	EUR
11	12-р сарын 30,	2033	250,000.00	261,000.00	511,000.00	EUR
12	6-р сарын 30,	2034	250,000.00	261,000.00	511,000.00	EUR
13	12-р сарын 30,	2034	250,000.00	261,000.00	511,000.00	EUR
14	6-р сарын 30,	2035	250,000.00	261,000.00	511,000.00	EUR
15	12-р сарын 30,	2035	250,000.00	261,000.00	511,000.00	EUR
16	6-р сарын 30,	2036	250,000.00	261,000.00	511,000.00	EUR
17	12-р сарын 30,	2036	250,000.00	261,000.00	511,000.00	EUR
18	6-р сарын 30,	2037	250,000.00	261,000.00	511,000.00	EUR
19	12-р сарын 30,	2037	250,000.00	261,000.00	511,000.00	EUR
20	6-р сарын 30,	2038	250,000.00	261,000.00	511,000.00	EUR



21	12-р сарын 30,	2038	250,000.00	261,000.00	511,000.00	EUR
22	6-р сарын 30,	2039	250,000.00	261,000.00	511,000.00	EUR
23	12-р сарын 30,	2039	250,000.00	261,000.00	511,000.00	EUR
24	6-р сарын 30,	2040	250,000.00	261,000.00	511,000.00	EUR
25	12-р сарын 30,	2040	250,000.00	261,000.00	511,000.00	EUR
26	6-р сарын 30,	2041	250,000.00	261,000.00	511,000.00	EUR
27	12-р сарын 30,	2041	250,000.00	261,000.00	511,000.00	EUR
28	6-р сарын 30,	2042	250,000.00	261,000.00	511,000.00	EUR
29	12-р сарын 30,	2042	250,000.00	261,000.00	511,000.00	EUR
30	6-р сарын 30,	2043	250,000.00	261,000.00	511,000.00	EUR
31	12-р сарын 30,	2043	250,000.00	262,000.00	512,000.00	EUR
32	6-р сарын 30,	2044	250,000.00	262,000.00	512,000.00	EUR
33	12-р сарын 30,	2044	250,000.00	262,000.00	512,000.00	EUR
34	6-р сарын 30,	2045	250,000.00	262,000.00	512,000.00	EUR
35	12-р сарын 30,	2045	250,000.00	262,000.00	512,000.00	EUR
36	6-р сарын 30,	2046	250,000.00	262,000.00	512,000.00	EUR
37	12-р сарын 30,	2046	250,000.00	262,000.00	512,000.00	EUR
38	6-р сарын 30,	2047	250,000.00	262,000.00	512,000.00	EUR
39	12-р сарын 30,	2047	250,000.00	262,000.00	512,000.00	EUR
40	6-р сарын 30,	2048	250,000.00	262,000.00	512,000.00	EUR
			10,000,000.00	10,450,000.00	20,450,000.00	EUR

- 4.5. Зээлийн эргэн төлөлт хуваарьт хугацаандаа төлөгдөөгүй тохиолдолд уг төлбөрийг энэхүү зүйлийн 4.9-д заасан СБЗБ-ны дансанд төлөгдөх хүртэл СБЗБ нь хугацаа хэтэрсэн төлбөрийн хэмжээнд жилийн суурь хүүг 3 хүртэлх хувиар нэмэгдүүлж бодох эрхтэй. “Суурь хүү” гэдэг нь төлбөр төлөгдөх ёстой байсан өдрийн Германы Холбооны банкнаас тогтоосон хүүг хэлнэ. Зээлийг эргэн төлөх хугацаа хэтэрсэн тохиолдолд СБЗБ нь учирсан хохирлыг барагдуулахыг шаардах эрхтэй. Уг хохирлын хэмжээ нь суурь хүү дээр жилийн 3 хувиар нэмэгдүүлсэн хүүгийн хэмжээнээс хэтрэхгүй байна.
- 4.6. Хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны хураамж, зээлийн хүү болон энэхүү зүйлийн 4.5-д заасан хугацаа хэтэрсэн төлбөрийн торгуулийг жилийн 360 хоногоор, сарын 30 хоногоор тооцно.
- 4.7. Ашиглагдаагүй болон хугацаанаас өмнө төлсөн зээлийг



шилжүүлэхдээ эргэн төлөх хуваарийн дагуу үлдсэн төлбөрт тэнцүү хэмжээгээр ногдуулах бөгөөд СБЗБ нь тодорхой нөхцөлд, тухайлбал төлбөрийн хэмжээ нь бага байвал өөр тусгай аргаар бие дааж тодорхойлно.

- 4.8. СБЗБ, Зээлдэгчийн хооронд байгуулсан бусад зээлийн хэлэлцээр болон энэхүү хэлэлцээрийн дагуу эргэн төлсөн зээлийн хөрөнгийг дахин зээлд ашиглах асуудлыг СБЗБ бие даан шийдвэрлэх эрхтэй.
- 4.9. Зээлдэгч нь аливаа төлбөрийг доорх данс хаягаар, еврогоор шилжүүлэх бөгөөд энэхүү төлбөрийг буцаан нэхэмжлэх эрхгүй.

Хүлээн авагч: СБЗБ (KfW)

SWIFT-BIC:

KFWIDEFFXXX

IBAN:

DE94 5002 0400 3139 4059 82

Таедугаар зүйл

Зээлийн санхүүжилтийг зогсоох, хугацаанаас өмнө төлбөр хийх

- 5.1. Зээлдэгч ямар ч үед:
- a) энэхүү гэрээний 8 дугаар зүйлийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхдээ ашиглагдаагүй байгаа зээлийн хөрөнгийг хэмжээ харгалзахгүй цуцлах,
 - b) зээлийг хугацаанаас нь өмнө бүхэлд нь эсвэл хэсэгчлэн эргүүлэн төлж болно.
- 5.2. СБЗБ нь доор дурдсанаас бусад тохиолдолд зээлийн ашиглалтыг цуцлах эрхгүй:
- a) Зээлдэгч нь зээлийн төлбөрийг хугацаанд нь СБЗБ-нд төлөх үүргээ биелүүлээгүй бол,
 - b) Энэхүү гэрээ болон тусгайлсан гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн бол,
 - c) Төсөл хэрэгжүүлэгч байгууллага нь зээлийн хөрөнгийг зориулалтын дагуу ашигласан гэдгээ нотолж чадахгүй байх,
 - d) Энэхүү гэрээний дагуу СБЗБ-ийн үүргийг биелүүлэх нь холбогдох хуулийг зөрчсөн бол,
 - e) төслийн зорилго, түүний хэрэгжүүлэлт, үйл ажиллагаанд эсхүл Зээлдэгчийн энэхүү гэрээгээр хүлээсэн үүргийнхээ дагуу төлбөр хийхэд давагдашгүй хүчин зүйлийн улмаас боломжгүй болох буюу ноцтой саад тотгор учирсан тохиолдолд.
- 5.3. Энэхүү зүйлийн 5.2-ын a), b), c) эсвэл d) хэсгүүдэд дурдсан нөхцөл байдал бий болсон тохиолдолд СБЗБ-наас тогтоосон 30 хоногоос багагүй хугацаанд асуудлыг шийдвэрлээгүй тохиолдолд СБЗБ нь дараах эрхтэй:

- a) Энэхүү зүйлийн 5.2-ын а), 5.2 b) эсвэл 5.2 d)-д заасан нөхцөл байдал үүссэн тохиолдолд зээлийн нийт үлдэгдэл, хуримтлагдсан нийт хүү болон бусад холбогдох бүх төлбөрийг нэн даруй буцааж төлөхийг шаардах,
- b) Энэхүү зүйлийн 5.2-ын с)-д заасан нөхцөл байдал үүссэн тохиолдолд, Төсөл хэрэгжүүлэгч байгууллага зээлийг зориулалтын дагуу ашигласан гэдгийг нотолж чадаагүй бол тухайн хэмжээний зээлийг нэн даруй буцааж төлөхийг шаардах.

Зургаадугаар зүйл

Зардал ба хураамж

- 6.1. Зээлдэгч нь энэхүү гэрээний дагуу хийх бүх төлбөрийг татвар, бусад хураамж, суутгалгүйгээр шилжүүлэх бөгөөд зээлийн хөрөнгийг шилжүүлэхтэй холбогдон гарсан зардал болон ханшийн зөрүүг төлнө.
- 6.2. Зээлдэгч нь ХБНГУ-ын нутаг дэвсгэрийн гадна энэхүү хэлэлцээрийг байгуулах, хэрэгжүүлэхтэй холбогдон гарах аливаа татвар, улсын хураамжийг хариуцна.

Долоодугаар зүйл

Хэлэлцээр хүчин төгөлдөр болох, төлөөлөх

- 7.1. Зээлдэгч нь анхны зээлийн санхүүжилт хийгдэхээс өмнө энэхүү Гэрээгээр хүлээх үүргээ биелүүлэхэд шаардлагатай өөрийн улсын Үндсэн хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн заалтуудыг бүрэн хангаж буйгаа нотолсон, СБЗБ-ны шаардлагыг хангахуйц баримтыг СБЗБ-нд хүргүүлнэ.
- 7.2. Монгол Улсын Сангийн сайд болон түүний СБЗБ-нд итгэмжлэн томилсон, баталгаат гарын үсэг бүхий этгээд энэхүү гэрээг хэрэгжүүлэхэд Зээлдэгчийг төлөөлнө. Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын Гүйцэтгэх захирал болон түүний СБЗБ-нд итгэмжлэн томилсон баталгаат гарын үсэг бүхий этгээд энэхүү гэрээг хэрэгжүүлэхэд Төсөл хэрэгжүүлэгч байгууллагыг төлөөлнө. Төлөөлөгч этгээдийн томилолтыг хүчингүй болгосон тухай мэдэгдлийг СБЗБ хүлээж авах хүртэл төлөөллийн бүрэн эрх хүчин төгөлдөр байна.
- 7.3. Энэхүү гэрээнд оруулах нэмэлт, өөрчлөлт болон гэрээтэй холбогдолтой бусад мэдэгдэл, тайлбарыг оролцогч талууд бие биедээ бичгээр хүргүүлнэ. Оролцогч талууд доорх хаягаар, эсхүл нөгөө талдаа мэдэгдсэн бусад хаягаар дээрх мэдэгдлийг хүлээн авснаар мэдэгдсэнд тооцно.



СБЗБ:	KfW Postfach 11 11 41 60046 Frankfurt am Main Federal Republic of Germany Fax: +49 69 7431-2944
Зээлдэгч:	Сангийн яам, Хөгжлийн санхүүжилтийн газар Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр, Д корпус, Улаанбаатар хот 15160, Монгол Улс
Төсөл хэрэгжүүлэгч байгууллага:	“Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК, Чингисийн өргөн чөлөө-45, Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот 17033, Монгол Улс

7.4. Энэхүү гэрээнд зөвхөн СБЗБ болон Зээлдэгчийн эрх зүйн харилцаатай холбоотой нэмэлт өөрчлөлт хийхэд Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын зөвшөөрөл шаардагдахгүй.

Наймдугаар зүйл

Төсөл

- 8.1. Төсөл хэрэгжүүлэгч байгууллага нь дараах үүргийг хүлээнэ:
- a) Төсөл хэрэгжүүлэгч байгууллага болон СБЗБ хоорондын тохирсон Төслийг хэрэгжүүлэх төлөвлөгөө болон санхүү, инженерийн туршлагад нийцүүлэн Төслийг бэлтгэх, хэрэгжүүлэх, зохион байгуулах, түүний хэвийн ажиллагааг хангах үүрэгтэй,
 - b) Төслийн хүрээнд хийгдэх барилгын ажилд бэлтгэх болон хяналт тавихад бие даасан, мэргэшсэн зөвлөхийг, мөн төсөл хэрэгжилтэд мэргэшсэн байгууллагыг тус тус томилно,
 - c) Урьдчилан явуулсан олон улсын өрсөлдөөнт сонгон шалгаруулалтын үндсэн дээр бараа, ажил, үйлчилгээ Зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэх гэрээг байгуулна.
 - d) Төсөлд шаардлагатай бүх бараа, ажил, үйлчилгээний төлбөрийн тодорхой жагсаалтыг гаргаж, эдгээр төлбөр нь Зээлийн хөрөнгөөр санхүүжигдсэн гэдгийг нотлох тайлан, мэдээлэл бүхий санхүүгийн баримт бичгийг хөтлөх үүргийг хүлээнэ.

- e) СБЗБ-ны төлөөлөгчдөд Төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой дээр дурдсан бүртгэл, тайлан болон бусад баримт бичгүүдийг шалгах, Төслийн хэрэгжилт, холбогдох байгууламжуудтай газар дээр нь танилцах нөхцөлөөр хангана.
 - f) СБЗБ-ны хүсэлтийн дагуу Төслийн арга хэмжээг хэрэгжүүлэх болон түүний цаашдын үйл явцтай холбоотой бүх мэдээ, тайланг СБЗБ-нд гаргаж өгнө.
 - g) Зээлийн хөрөнгөөр санхүүжигдэх бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний талаар “Хөгжлийн албан ёсны тусламжийн зээлийн ил тод байдлын хэлэлцээр”-ийн дагуу Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага эсхүл түүний гишүүдийн зүгээс Зээлдэгчид тавьсан аливаа асуулгыг хугацаа алдалгүй СБЗБ-нд дамжуулах бөгөөд асуулгын хариуг СБЗБ-тай зөвшилцөнө.
- 8.2. Төсөл хэрэгжүүлэгч байгууллага болон СБЗБ нь энэ зүйлийн 8.1-д заасан асуудлуудыг Тусгайлсан гэрээгээр нарийвчлан зохицуулна.
- 8.3. Зээлдэгч болон Төсөл хэрэгжүүлэгч байгууллага доорх үйл ажиллагааг хэрэгжүүлэх ёстой:
- a) Төслийн бүх санхүүжилтийг баталгаажуулж, шаардлагатай тохиолдолд СБЗБ-ны хүсэлтээр зээлийн хөрөнгөөр санхүүжигдээгүй бусад зардлыг шийдвэрлэсэн гэсэн нотлох баримтыг гаргаж өгнө.
 - b) Төслийн зорилт, үйл ажиллагаа, хэрэгжилтэд сөргөөр нөлөөлөх, ноцтой саад учруулах аливаа нөхцөл байдлын талаар СБЗБ-нд нэн даруй мэдэгдэнэ.
- 8.4. Зээлдэгч нь Төсөл хэрэгжүүлэгч байгууллагад Төслийг хэрэгжүүлэх болон энэхүү Зээлийн хэлэлцээрээр хүлээсэн үүргээ биелүүлэхэд санхүүгийн болон инженерийн туршлага, холбогдох санхүүгийн арга барилаар туслалцаа үзүүлэх бөгөөд ялангуяа Төсөл хэрэгжүүлэгч байгууллагад энэ төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай бүхий л зөвшөөрлийг олгоно.
- 8.5. Энэхүү Зээлийн хөрөнгөөр санхүүжигдэх бараа, материалыг тээвэрлэхэд Засгийн газар хоорондын хэлэлцээрийн нөхцөлүүд хэрэглэгдэнэ.

Есдүгээр зүйл

Төсөлтэй холбогдолтой мэдээллийг нийтлэх болон шилжүүлэх

- 9.1. Төслийн талаар (үнэлгээний тайлангийн хамт) болон гэрээний өмнөх хэлэлцээрийн үеэр хэрхэн санхүүжих талаар мэдээлэл гаргах, Төсөлтэй холбоотой гэрээг хэрэгжүүлж байх үед болон дараах үе шатанд (цаашид «Бүхий л цаг үе» гэх) хөгжлийн хамтын ажиллагааны хүрээнд ил тод байдал, үр ашгийн талаархи



олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн зарчмуудыг дагаж мөрдөх, Төслийн талаар (үнэлгээний тайлангийн хамт) болон гэрээний өмнөх хэлэлцээрийн үеэр хэрхэн санхүүжих талаар мэдээлэл гаргах.

Мэдээлэл нь СБЗБ-ны “KfW Development Bank” (<http://transparenz.kfw-entwicklungsbank.de/>) бизнесийн вэбсайт дээр тогтмол нийтлэгдэнэ.

Нийтлэх мэдээлэлд (СБЗБ эсвэл гуравдагч этгээд нь доорх 9.3-р зүйлийн дагуу) Төслийн талаар болон хэрхэн санхүүжиж байгаа нь гэрээний баримт бичиг эсвэл Төсөлд оролцсон талуудын талаархи санхүүгийн болон бизнесийн холбогдолтой нарийвчилсан мэдээлэл, жишээ нь:

- a. Санхүүгийн дотоод мэдээллийн талаар;
- b. Бизнесийн стратеги;
- c. Компанийн дотоод удирдамж, тайлан;
- d. Хүмүүсийн хувийн мэдээлэл;
- e. Талуудын санхүүгийн байдлийн талаарх СБЗБ-ны дотоод үнэлгээ.

9.2 СБЗБ нь төслийн үйл ажиллагаа хэрхэн санхүүжиж байгаа талаарх мэдээллийг төсөл хэрэгжих бүхий л цаг үед дор дурдсан байгууллагуудад ил тод, үр ашигтай байдлыг хангахын тулд тодорхой мэдээллийг хуваалцана.

- a) СБЗБ-ны салбарууд;
- b) Холбооны Бүгд Найрамдах Герман Улс болон түүний эрх бүхий байгууллага, институт, агентлаг аль эсвэл аж ахуй нэгж;
- c) Германы хоёр талын хөгжлийн хамтын ажиллагааны чиглэлээр ажилладаг бусад хэрэгжүүлэгч байгууллагууд, ялангуяа Deutsche Gesellschaft Internationale Zusammenarbeit (GIZ) GmbH;
- d) Статистикийн мэдээг цуглуулах олон улсын байгууллага түүний гишүүд ялангуяа Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ) болон түүний гишүүд.

9.3 Түүнчлэн, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын тавьсан хүсэлтийн дагуу СБЗБ нь төслийн талаар болон хэрхэн санхүүжиж байгаа талаарх мэдээллийг төсөл хэрэгжих бүхий л цаг үед дараах нэгжүүдэд (энэ төслийн зорилгод хамаарах нэгжүүдэд мэдээлэх).

- a) Олон улсын тусламжийн ил тод байдлын санаачлагын зорилгоор Холбооны Бүгд Найрамдах Герман Улс (http://www.bmz.de/de/was_wir_machen/wege/transparenz-fuer-mehr-Wirk-samkeit/index.html);
- b) Герман Худалдаа ба Хөрөнгө оруулалт (GTAI) зах зээлийн мэдээллийн зорилгоор (<http://www.gtai.de/GTAI/Navigation/DE/trade.FOO>);

- c) Хөгжлийн хамтын ажиллагааны хүрээнд санхүүгийн урсгалыг тайлагнах зорилгоор ЭЗХАХБ (<http://stats.oecd.org/>);
- d) Германы Хөгжлийн Үнэлгээний Хүрээлэн (DEVal) нь Германы ерөнхий хөгжлийн хамтын ажиллагааг үнэлэх зорилгоор ил тод, үр ашигтай байдлыг хангах (<http://www.deval.org/de/>).

9.4 Төслийн талаар болон хэрхэн санхүүжиж буй талаарх мэдээллийг төслийн бүхий л цаг үед хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахын тулд бусад гуравдагч этгээдэд СБЗБ цаашид шилжүүлэх эрхтэй (үүнд хэвлэн нийтлэх зорилгоор).

KfW нь гуравдагч этгээдэд нэмэлт мэдээлэл дамжуулах сонирхолтой боловч Зээлдэгч болон Төсөл хэрэгжүүлэх байгууллага нь нэмэлт мэдээлэл гуравдагч этгээдэд нийтлэхгүй гэсэн хууль зүйн үндэслэл байвал СБЗБ нь нэмэлт мэдээлэл гуравдагч этгээдэд дамжуулахгүй. Зээлдэгч буюу Төсөл хэрэгжүүлэх байгууллагын хууль ёсны ашиг сонирхол нь 9.1-д дурдсан эмзэг мэдээллийг нууцлахад хамаарна. Энэ нь нийтлэлээс хасагдана.

Цаашилбал, СБЗБ нь хууль тогтоомж, зохицуулалтын шаардлагууд, шүүхийн болон захиргааны журмаар нэхэмжлэлийн болон шүүхийн бусад эрхүүдийг баталгаажуулах буюу хамгаалах үүднээс шаардлагатай бол гуравдагч этгээдэд мэдээллийг шилжүүлэх эрхтэй.

10 дугаар зүйл

Бусад зүйл

10.1. Зээлдэгч болон Төсөл хэрэгжүүлэгч байгууллага нь төслийн бэлтгэл ажлыг хангах, хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн хүмүүс төслөөр санхүүжигдэх бараа, үйлчилгээний гэрээ байгуулахад хууль бус төлбөрийг амлах, хийлгэх, өгөх, бэлэглэх, нэхэх, асуух, эсвэл бусад ажилтай холбоотойгоор ямар нэг давуу талыг бий болгохгүй байх үүрэг хүлээнэ.

10.2. Төсөл хэрэгжүүлэгч байгууллага нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх болон Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын бизнесийн харилцааг хянах зорилгоор СБЗБ-наас хүссэн шаардлагатай бүх мэдээлэл, баримт бичгийг СБЗБ-нд даруй гаргаж өгнө.

Энэхүү Зээлийн хэлэлцээрийг хэрэгжүүлэхэд Төсөл хэрэгжүүлэх байгууллага нь өөрийн нэр, өөрийн дансаар оролцоно. ХБНГУ-ын хууль болон Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын харьяалагдах улсын хуулийн дагуу:

- a) Төсөлд зориулж Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын



- өөрийн хөрөнгийн эх үүсвэрээс санхүүжүүлэх хөрөнгө нь хууль бус эх үүсвэргүй байх ялангуяа хар тамхины худалдаа, авилга, зохион байгуулалттай гэмт хэрэг, терроризм гэх мэттэй холбогдсон байж болохгүй.
- b) Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын хувь нийлүүлэгчдийн хөрөнгө нь ямар ч үед хууль бус эх үүсвэргүй байх, ялангуяа хар тамхины худалдаа, авилга, зохион байгуулалттай гэмт хэрэг, терроризм гэх мэттэй холбоогүй байх.
 - c) Төсөл хэрэгжүүлэгч байгууллага нь хууль бус эх үүсвэр, ялангуяа хар тамхины худалдаа, авилга, зохион байгуулалттай гэмт хэрэг, терроризм гэх мэттэй холбоотой хөрөнгийг олж авах, эзэмшиж, хэрэглэж болохгүй.
 - d) Төсөл хэрэгжүүлэгч байгууллага нь санхүүгийн терроризмд оролцож болохгүй.
- 10.3. Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын төлөөлөгч нар нь ямар нэгэн бизнесийн ашиг сонирхол, харилцан хамааралгүй, аливаа бусад үйл ажиллагаанд оролцоогүй байх
- a) Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн Зөвлөл, Европын Холбоо, эсвэл Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын ("Хориг арга хэмжээ авсан жагсаалт") -аас олгосон шийтгэлийн жагсаалтад орсон хувь хүн, байгууллага, аж ахуйн нэгжийг
 - b) гадаад худалдааны зохицуулалтыг хориглох буюу дээр дурдсан байгууллагуудаас ("Хориг арга хэмжээ авсан жагсаалт") олгосон санхүүгийн хориг арга хэмжээг зөрчсөн гэж үзэх болно.
- Төсөл хэрэгжүүлэгч байгууллага нь Хорионы жагсаалтад орсон хувь хүн, байгууллага, аж ахуйн нэгжтэй бизнесийн аливаа харилцаа холбоо тогтоож, үргэлжлүүлэхгүй бөгөөд шийтгэлийг зөрчсөн аливаа үйл ажиллагаанд оролцохгүй болно.
- 10.4. Хориог зөрчсөн төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой аливаа бусад үйл ажиллагаанд Зээлдэгч ямар ч ажил гүйлгээ хийхгүй, оролцохгүй.
- 10.5. Энэхүү гэрээний аль нэг заалт хүчингүй болох тохиолдолд бусад заалтууд хүчин төгөлдөр хэвээр үлдэнэ. Хүчингүй болсон заалтыг гэрээний зорилгод нийцсэн өөр заалтаар орлуулна.
- 10.6. Зээлдэгч болон Төсөл хэрэгжүүлэгч байгууллага нь энэхүү гэрээгээр хүлээсэн аливаа эрхээ бусдад шилжүүлэх, дэнчин барьцаа болгож болохгүй.
- 10.7. СБЗБ нь шаардах эрх үүссэнийг мэдсэн буюу мэдэх боломжтой байсан тохиолдолд энэ эрхээ хэрэгжүүлээгүй бол хөөн хэлэлцэх



хугацаа таван жил байна.

10.8. Энэхүү Зээлийн гэрээ нь ХБНГУ-ын хууль, тогтоомжийг удирдлага болгоно. Удирдан гүйцэтгэх газар нь Франкфурт ам Майн хот байна.

10.9. Энэхүү Зээлийн гэрээний дагуу болон холбоотойгоор үүсэх бүхий л маргаан нь зөвхөн арбитрын шүүхээр эцэслэн шийдвэрлэгдэнэ. Энэ тохиолдолд доорх зүйлүүд хамаарна:

а) Арбитрын шүүх нь нэг эсвэл гурван томилогдсон арбитрчаас бүрдэх бөгөөд тэднийг тухайн үед Олон улсын худалдааны танхимын арбитрын дүрмийн дагуу томилж, тэд үйл ажиллагаагаа дээрх дүрмийн дагуу явуулна.

б) Арбитрын шүүх хурал нь Франкфурт ам Майн хотод болно. Шүүх хурал Англи хэлээр явагдана.

Энэхүү Зээлийн гэрээг Англи хэл дээр 3 эх хувь үйлдэв.

Улаанбаатар хот,

Улаанбаатар хот

СБЗБ (KfW)

Монгол Улсыг төлөөлж
Сангийн яам
“Цахилгаан дамжуулах

МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

ЯЛТАН ШИЛЖҮҮЛЭХ ТУХАЙ

МОНГОЛ УЛС БОЛОН

БҮГД НАЙРАМДАХ СОЦИАЛИСТ ВЬЕТНАМ УЛС

ХООРОНДЫН ГЭРЭЭ

Монгол Улс болон Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс (цаашид бие даан “тал”, хамтран “талууд” гэх/;

ялтны ялыг харьяалах улсад эдлүүлэх нь тэднийг эргэн нийгэмшихэд тус дөхөм болохыг ХАРГАЛЗАН;

эрүүгийн гэмт хэрэг үйлдсэний улмаас ял шийтгүүлсэн иргэдэд өөрсдийн нийгэмдээ ял эдлэх боломж олгохыг АНХААРЧ ҮЗЭН;

дараах зүйлийг ХЭЛЭЛЦЭН ТОХИРОЛЦОВ. Үүнд:



1 ДҮГЭЭР ЗҮЙЛ

Тодорхойлолт

Энэхүү гэрээний зорилгоор:

1. “Шилжүүлэгч тал” гэж ял оногдуулсан болон ялтныг өөрийн нутаг дэвсгэрээсээ шилжүүлэн өгөх боломжтой, эсхүл шилжүүлсэн талыг хэлнэ.
2. “Хүлээн авагч тал” гэж ялтныг өөрийн нутаг дэвсгэртээ шилжүүлэн авах боломжтой, эсхүл ялыг үргэлжлүүлэн эдлүүлэхийн тулд шилжүүлэн авсан талыг хэлнэ.
3. “Ял” гэж эрүүгийн хэрэгт шилжүүлэгч талын шүүн таслах ажиллагааны явцад шүүхээс хугацаатай, эсхүл хугацаагүй хорьж эрх чөлөөг нь хязгаарлах зэргээр авсан арга хэмжээ, эсхүл аливаа шийтгэлийг хэлнэ.
4. “Ялтан” гэж шилжүүлэгч талын нутаг дэвсгэрт шилжүүлэгч талын шүүхээс оногдуулсан ялын дагуу хорих анги, түр саатуулах байр болон бусад байгууллагад хорих ял эдэлж буй этгээдийг хэлнэ.
5. “Иргэн” гэж Монгол Улс болон Вьетнам Улсын харьяат этгээдийг хэлнэ.
6. “Эрх бүхий төв байгууллага” гэж энэхүү гэрээг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагыг хэлнэ.
7. “Эрх бүхий байгууллагууд” гэж энэхүү гэрээний дагуу хүсэлтийг гүйцэтгэх талуудын эрх бүхий байгууллагуудыг хэлнэ.

2 ДУГААР ЗҮЙЛ

Ерөнхий зарчим

1. Талууд энэхүү гэрээнд заасны дагуу ялтан шилжүүлэх ажиллагааг хэрэгжүүлэхийн тулд бүхий л арга хэмжээг авч хамтран ажиллана.
2. Энэхүү гэрээний заалтын дагуу шилжүүлэгч талын шүүхээс оногдуулсан ялыг үргэлжлүүлэн эдлүүлэх зорилгоор ялтныг шилжүүлэгч талын нутаг дэвсгэрээс хүлээн авагч талын нутаг дэвсгэрт шилжүүлэн өгч болно.
3. Ялтан шилжүүлэх тухай хүсэлтийг шилжүүлэгч тал, хүлээн авагч тал, эсхүл ялтан өөрөө гаргаж болно.
4. Энэхүү гэрээний дагуу хүлээн авагч тал ялтанд ижил төрлийн гэмт хэрэгт дахин яллах, шүүх болон ял оногдуулж болохгүй.

3 ДУГААР ЗҮЙЛ

Эрх бүхий төв байгууллага

1. Гэрээнд өөрөөр заагаагүй бол энэхүү гэрээний зорилгоор талууд өөрсдийн томилсон эрх бүхий төв байгууллагаар шууд харилцана.
 - (a) Монгол Улсын эрх бүхий төв байгууллага нь Хууль зүй, дотоод хэргийн яам;
 - (b) Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын эрх бүхий төв байгууллага нь Нийгмийн аюулгүй байдлын яам байна.
2. Талуудын эрх бүхий төв байгууллага нь шилжүүлэх хүсэлтийг энэхүү гэрээний нөхцөл болон талуудын хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлнэ.
3. Хэрэв талуудын эрх бүхий төв байгууллага өөрчлөгдсөн тохиолдолд энэ тухайгаа дипломат шугамаар нөгөө талдаа бичгээр мэдэгдэнэ.

4 ДҮГЭЭР ЗҮЙЛ

Шилжүүлэх нөхцөл

1. Ялтныг энэхүү гэрээний дагуу дараах нөхцөлд шилжүүлж болно. Үүнд:
 - (a) Ялтан нь хүлээн авагч талын иргэн байх;
 - (b) Шилжүүлэгч талын шүүхийн эцсийн шийдвэр гарсан бөгөөд шилжүүлэгч талд хэрэгтэй холбоотой байцаан шийтгэх ажиллагаа дууссан байх;
 - (c) Ялтан шилжүүлэх хүсэлтийг хүлээн авах үед уг ялтны эдлэх ялын хугацаанаас нэгээс (1) доошгүй жил, онцгой тохиолдолд зургаан (6) сараас доошгүй хугацаа үлдсэн байх;
 - (d) Шилжүүлэх зөвшөөрлийг ялтан өөрөө, эсхүл тухайн ялтны чадамжгүй нөхцөл байдлаас шалтгаалан түүний хууль ёсны төлөөлөгч зөвшөөрлийг гаргаж болно;
 - (e) Ялтны үйлдэл, эс үйлдэлд ял оногдуулсан байдал нь хүлээн авагч талын хуулиар эрүүгийн гэмт хэрэгт тооцогддог байх, энэ нөхцөл байдал нь талуудын хууль тогтоомжийн дагуу гэмт хэргийн тодорхойлолт нь адилхан тайлбартай байхыг шаардахгүй;
 - (f) Талууд ялтан шилжүүлэхийг харилцан зөвшөөрсөн байх;
 - (g) Ялтан нь шүүхийн тогтоолын дагуу нэмэлт ял шийтгэл хүлээсэн буюу торгууль төлөх, эд хөрөнгө хураалгах болон бусад иргэний үүргээ биелүүлсэн байх.
2. Энэхүү гэрээний заалтыг насанд хүрээгүй этгээдэд ногдуулсан ялын хувьд хэрэглэхдээ талууд тус тусын хууль тогтоомжийн дагуу харилцан тохиролцож болно. Ямар ч тохиолдолд насанд хүрээгүй этгээдийн өмнөөс түүний хууль ёсны төлөөлөгчийн зөвшөөрлийг авах шаардлагатай.



5 ДУГААР ЗҮЙЛ

Шилжүүлэхээс татгалзах

Энэхүү гэрээний дагуу дараах тохиолдолд ялтанг шилжүүлэхээс татгалзаж болно. Үүнд:

1. Хүлээн авагч тал ялтан шилжүүлэн авсны дараа түүнд эрүү шүүлт тулгах, эсхүл хэрцгий болон хүнлэг бус шийтгэл ногдуулах магадлалтай гэх үндэслэл байвал;

2. Ялтан шилжүүлэх нь хүлээн авагч талын бүрэн эрх, аюулгүй байдал, нийгмийн хэв журам, эсхүл нийтийн үндсэн эрх ашигт хохирол учруулахаар бол.

6 ДУГААР ЗҮЙЛ

Шилжүүлэх журам

1. Талууд энэхүү гэрээний дагуу ялтанд, хэрэв ялтан чадамжгүй тохиолдолд түүний хууль ёсны төлөөлөгчид түүний шилжих эрхийг танилцуулах талаар бүхий л арга хэмжээг авна.

2. Хэрэв ялтан шилжихийг хүсвэл тэрээр уг хүсэлтээ аль ч талд гаргаж болох бөгөөд хүсэлтийг хүлээн авсан тал нөгөө талдаа энэ тухай даруй бичгээр мэдэгдэнэ.

3. Шилжих хүсэлт гаргасан бол, шилжүүлэгч тал хүлээн авагч талд дараах мэдээлэл болон баримт бичгийг бичгээр өгнө. Үүнд:

- (a) Ялтны овог, нэр, хүйс, харьяалал, зураг, хурууны хээ, төрсөн огноо, төрсөн газар;
- (b) Боломжтой тохиолдолд ялтны харьяаллын байдлыг тодорхойлсон баримт бичиг;
- (c) Ялтны хүлээн авагч талд сүүлд оршин сууж байсан хаяг;
- (d) Ялын төрөл, ялын үргэлжлэх, эхлэх болон дуусгавар болох хугацаа, эдэлсэн хугацаа, ялыг хөнгөрүүлсэн хугацаа, цагдан хоригдсон хугацаа болон бусад хасагдсан хугацааны талаарх бусад мэдээлэл;
- (e) Ялын болон тогтоолын хуулбар болон гэмт хэргийг тодорхойлсон холбогдох хуулийн мэдээлэл;
- (f) Тус гэрээний 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн (d)-д заасан бичгээр гаргасан шилжүүлэх зөвшөөрөл;
- (g) Шилжүүлэгч тал шаардлагатай үед ялтны эрүүл мэнд, эсхүл нийгмийн байдлын талаарх мэдээлэл, шилжүүлэгч талд түүний эмчлүүлж байгаа тухай мэдээлэл болон хүлээн авагч талд цаашид хийх эмчилгээний тухай аливаа зөвлөмжийг өгнө.
- (h) Хүлээн авагч талын хүссэн бусад нэмэлт мэдээлэл.

4. Энэхүү гэрээний дагуу ялтан шилжих тухай хүсэлтээ хүлээн авагч талд гаргасан бол шилжүүлэгч тал тус зүйлийн 3 дахь хэсэгт заасан мэдээллийг баримт бичгийн хамт нөгөө талдаа өгнө.

5. Хүлээн авагч тал шилжүүлэгч талаас ирүүлсэн мэдээлэл нь шаардлага хангасан гэж үзвэл ялтан шилжүүлэх ажиллагааг явуулах тухайгаа дараах мэдээлэл, баримт бичгийн хамт шилжүүлэгч талд бичгээр хүргүүлнэ. Үүнд:

- (a) Ялтан нь энэхүү гэрээний 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн (a)-д заасан шаардлагыг хангаж байгаа талаарх баримт бичиг болон тодорхойлолтын хуулбар;
- (b) Үйлдэл, эс үйлдэлд шилжүүлэгч талын ял оногдуулсан үйлдэл, эсхүл хүлээн авагч талын нутаг дэвсгэрт үйлдэгдэх хэрэгт хүлээн авагч талын хуулиар эрүүгийн гэмт хэрэгт тооцогдох тухай холбогдох хуулийн хуулбар;
- (c) Хүлээн авагч тал тухайн ялтанд ялыг хэрхэн эдлүүлэх талаар тодорхойлолт;
- (d) Шаардлагатай бусад нэмэлт мэдээлэл.

6. Аль нэг тал хэрэв нөгөө тал хүсвэл, шилжүүлэх хүсэлт гаргах, эсхүл шилжүүлэхийг зөвшөөрөх эсэх шийдвэрийг гаргахаасаа өмнө холбогдох мэдээлэл, баримт бичиг, эсхүл баримтыг боломжийн хэрээр нөгөө талдаа гаргаж өгнө.

7. Хүлээн авагч тал болон шилжүүлэгч тал тус зүйлийн дээрх хэсгүүдэд заасны дагуу гаргасан аливаа шийдвэрийг тухайн ялтанд бичгээр мэдэгдэнэ.

7 ДУГААР ЗҮЙЛ

Хүсэлт гаргах болон хариу өгөх

1. Энэхүү гэрээнд заасны дагуу шилжих хүсэлт болон хариуг бичгээр, эсхүл ямарваа нэгэн нотлох аргаар үйлдэж аль ч эрх бүхий төв байгууллагад мэдэгдэнэ.

2. Хүсэлтийн хариуг мөн адил шугамаар мэдэгдэнэ.

3. Хүлээн авагч тал шилжүүлэх хүсэлтийг хэрхэн шийдвэрлэсэн тухайгаа шилжүүлэгч талд даруй мэдэгдэнэ.

8 ДУГААР ЗҮЙЛ

Ялтны зөвшөөрөл ба түүний нотолгоо

1. Талууд 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн (d)-д заасны дагуу шилжихийг зөвшөөрсөн ялтан шийдвэр гаргахдаа сайн дураар зөвшөөрсөн эсэхийг шилжүүлэгч тал баталгаажуулна.



2. Шилжүүлэгч тал ялтан шилжүүлэх зөвшөөрлийг тус зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу ялтан шилжүүлсний улмаас үүсэн гарах эрх зүйн үр дагаврыг бүрэн ойлгуулсны үндсэн дээр шилжих зөвшөөрлөө сайн дураар өгөх нөхцөлийг хангасан талаар өөрийн бүрэн эрхт төлөөлөгчөөрөө дамжуулан баталгаажуулах боломжийг хүлээн авагч талд олгоно.

9 ДҮГЭЭР ЗҮЙЛ

Ялыг үргэлжлүүлэн эдлүүлэх

1. Ялтныг шилжүүлсний дараа ялыг үргэлжлүүлэн эдлүүлэх, хорих ялын хугацааг багасгах, ялаас чөлөөлөх ажиллагааг хүлээн авагч талын хуулиар зохицуулна.

2. Хүлээн авагч тал нь ялтныг хүлээн авсны дараа шилжүүлэгч талаас оногдуулсан ялын төрөл, хугацааны дагуу ялыг үргэлжлүүлэн эдлүүлнэ.

3. Хэрэв шилжүүлэгч талаас оногдуулсан ялын төрөл эсхүл хугацаа нь хүлээн авагч талын хуультай нийцэхгүй бол тухайн ялыг өөрийн хуульд заасан ижил төрлийн гэмт хэргийн ялтай нийцүүлж болно. Ингэхдээ хүлээн авагч талын эрх бүхий этгээд шилжүүлэгч талын гэм буруутайд тооцсон шүүхийн тогтоол, оногдуулсан ял зэрэг цуглуулсан нотлох баримт дээр тулгуурлаж шийдвэрээ гаргана. Нийцүүлсэн ял нь шилжүүлэгч талын оногдуулсан ялын хугацаа, төрлөөс хүнд байж болохгүй бөгөөд хүлээн авагч талын хуулиар тогтоосон ялын дээд хэмжээнээс хэтрүүлэхгүй. Хүлээн авагч талын эрх бүхий этгээд ялыг нийцүүлэхдээ биеэр эдлэх ял шийтгэлийг өөр бусад хэлбэрээр эдлүүлэхээр өөрчилж болохгүй.

4. Хэрэв хүлээн авагч талын хуулиар ялтан нь насанд хүрээгүй этгээдэд тооцогдохоор бол шилжүүлэгч талын хуулиар түүний эрх зүйн байдал ямар байсныг үл харгалзан ялтныг насанд хүрээгүй этгээдээр тооцож болно.

5. Хүлээн авагч тал нь шилжүүлэгч талаас тухайн ялтныг өршөөсөн эсхүл ялыг бууруулсан буюу чөлөөлсөн тухай шийдвэрийг хүлээн авсан даруйд ял эдлүүлэх ажиллагааг энэхүү гэрээний 10 дугаар зүйлд заасны дагуу өөрчлөх, эсхүл хүчингүй болгоно.

6. Тус зүйлийн 1-5 хүртэлх хэсгийн дагуу талууд ялтан шилжүүлэх ажиллагаатай холбоотой гаргасан аливаа шийдвэр болон үйл ажиллагааг тухайн ялтанд бичгээр мэдэгдэнэ.

10 ДУГААР ЗҮЙЛ

Хэргийн харьяаллыг хэвээр
үлдээх, уучлал, өршөөл үзүүлэх

1. Шилжүүлэгч тал нь өөрийн шүүхээс оногдуулсан ял болон шийтгэлийг хянах хэргийн харьяаллыг хэвээр хадгална.
2. Аль ч тал өөрсдийн Үндсэн хууль, эсхүл бусад хуулийн дагуу ялтанд уучлал, өршөөл үзүүлэх, эсхүл ялыг хөнгөрүүлж болох бөгөөд энэ шийдвэрийн талаар нөгөө талдаа нэн даруй мэдэгдэнэ.

11 ДҮГЭЭР ЗҮЙЛ

Ялтныг дамжин өнгөрүүлэх

1. Хэрэв аль нэг тал ялтныг гуравдагч улсын нутаг дэвсгэрээр дамжуулан шилжүүлэхээр бол нөгөө тал нь өөрийн хуулийн дагуу дор дурдсанаас бусад тохиолдолд тухайн ялтныг нутаг дэвсгэрээрээ дамжин өнгөрүүлэхэд дэмжлэг үзүүлж хамтран ажиллана:
 - (a) Хэрэв шилжүүлж буй ялтан тухайн улсын иргэн бол;
 - (b) Хэрэв дамжин өнгөрөх хүсэлт нь хэлэлцэн тохирогч талын бүрэн эрх, аюулгүй байдал, нийгмийн хэв журам, эсхүл бусад эрх ашигт хохирол учруулахаар бол;
2. Шилжүүлэх арга хэмжээ авах гэж байгаа тал нөгөө талдаа дамжин өнгөрүүлэх талаар урьдчилан мэдэгдсэн байна.

12 ДУГААР ЗҮЙЛ

Зардал

Хүлээн авагч тал ялтныг шилжүүлэхтэй холбоотой шилжүүлэгч талын нутаг дэвсгэр дээр гаргасан зардлаас бусад зардал болон ялтныг шилжүүлсний дараа ялыг үргэлжлүүлэн эдлүүлэхтэй холбогдон гарах зардлыг хариуцна. Хүлээн авагч тал ялтан шилжүүлэхтэй холбогдон гарсан зардлыг ялтнаас, эсхүл бусад эх үүсвэрээс бүхэлд нь болон хэсэгчлэн төлөхийг шаардах эрхтэй.

13 ДУГААР ЗҮЙЛ

Харилцах хэл

1. Тус гэрээний 6 болон 7 дугаар зүйлийн дагуу гаргасан шилжүүлэх хүсэлт түүнчлэн бусад холбогдох баримт бичиг, мэдээллийг хүлээн авагч талын албан ёсны хэл, эсхүл англи хэлээр хүргүүлнэ.
2. Энэхүү гэрээний 3 дугаар зүйлд заасан эрх бүхий төв байгууллага хоорондоо харилцахдаа харилцах хэлээ тохиролцож, эсхүл англи хэлээр харилцана.



14 ДҮГЭЭР ЗҮЙЛ

Ял эдлүүлэх ажиллагааны талаар мэдээлэх

Хүлээн авагч тал нь дараах тохиолдолд шилжүүлэх талыг ял эдлүүлэх ажиллагааны талаарх мэдээллээр хангана. Үүнд:

1. Зарим нөхцөлийн дагуу ялтны ялын хугацаа хасагдсан, эсхүл тэнсэн суллагдсан;
2. Хүлээн авагч тал тухайн ялтан эдэлбэл зохих ялыг эдэлж дууссан гэж үзсэн;
3. Ялтан ял эдэлж дуусахаас өмнө хорих газраас оргон зайлсан, эсхүл нас барсан;
4. Шилжүүлэгч талаас тусгайлан мэдээлэл хүссэн бол.

15 ДУГААР ЗҮЙЛ

Ялтныг шилжүүлэх

1. Ялтныг шилжүүлэх тов, газрыг шилжүүлэгч тал болон хүлээн авагч тал харилцан тохиролцож шийдвэрлэнэ. Хүлээн авагч тал ялтныг шилжүүлэгч талаас шилжүүлэн авах тээвэрлэлт болон шилжүүлэгч талын нутаг дэвсгэрээс гадна хорионд байх асуудлыг бүрэн хариуцна.

2. Ялтныг шилжүүлэх шийдвэрийг англи хэлээр тус бүр 2 хувь бичгээр үйлдэх бөгөөд эх бичвэрүүд адил хүчинтэй байна. Талууд тус бүр нэг хувийг хадгална.

16 ДУГААР ЗҮЙЛ

Маргаан шийдвэрлэх

Энэхүү гэрээг тайлбарлах болон хэрэгжүүлэхтэй холбогдон гарах аливаа маргааныг талуудын эрх бүхий төв байгууллага хоорондоо зөвлөлдөн шийдвэрлэнэ. Хэрэв талуудын эрх бүхий төв байгууллага хоорондоо зөвшилцөлд хүрч шийдвэрлэх боломжгүй тохиолдолд дипломат шугамаар шийдвэрлэнэ.

17 ДУГААР ЗҮЙЛ

Бусад гэрээнүүд

Энэхүү гэрээ нь талуудын нэгдэн орсон олон улсын гэрээ болон бусад хэлэлцээрийн хүрээнд хүлээсэн эрх үүрэгт хамаарахгүй.

18 ДУГААР ЗҮЙЛ

Зөвлөлдөх

1. Аль ч талын хүсэлтээр энэхүү гэрээг хэрэглэх болон тайлбарлахтай холбоотой асуудлаар талууд хамтран зөвшилцөнө.
2. Талуудын эрх бүхий төв байгууллагууд энэхүү гэрээтэй

холбоотой үүсэх онцгой нөхцөл болон тус гэрээг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дэмжих талаар хамтран ажиллана.

19 ДҮГЭЭР ЗҮЙЛ

Хүчин төгөлдөр болох,
нэмэлт, өөрчлөлт оруулах ба цуцлах

1. Талууд энэхүү гэрээг хүчин төгөлдөр болгох дотоодын хууль тогтоомжийн шаардлагыг хангасан тухайгаа нөгөө талд бичгээр мэдэгдэнэ. Энэхүү гэрээ хоёр мэдэгдлийн хамгийн сүүлд хүлээн авсан өдрөөс хойш гуч (30) дахь өдрөөс хүчин төгөлдөр болно.

2. Энэхүү гэрээ нь хүчин төгөлдөр болохоос өмнөх хэрэгт болон хүчин төгөлдөр болсны дараа ял шийтгүүлсэн ялтныг шилжүүлэхэд үйлчилнэ.

3. Энэхүү гэрээнд харилцан зөвшилцсөний үндсэн дээр бичгээр нэмэлт, өөрчлөлт оруулна. Аливаа нэмэлт, өөрчлөлт нь тус гэрээний хүчин төгөлдөр болсон арга замын дагуу хүчин төгөлдөр болно.

4. Энэхүү гэрээ нь тодорхой бус хугацаагаар хүчин төгөлдөр хэвээр үлдэнэ. Аль ч тал, хэдийд ч энэхүү гэрээг дуусгавар болгох тухай хүсэлтийг дипломат шугамаар нөгөө талдаа бичгээр мэдэгдэж болно. Гэрээг дуусгавар болгох тухай мэдэгдлийг нөгөө тал хүлээн авсан өдрөөс хойш нэг зуун наяд (180) дахь өдрөөс дуусгавар болно. Гэрээ дуусгавар болох нь гэрээ дуусгавар болохоос өмнө эхэлсэн ялтан шилжүүлэх ажиллагаанд нөлөөлөхгүй.

ДЭЭР ДУРДСАНЫГ НОТОЛЖ, талуудын Засгийн газраас бүрэн эрх олгосны дагуу энэхүү гэрээнд гарын үсэг зурав.

Энэхүү гэрээг 2018 оны 10 дугаар сарын 16-ны өдөр Ханой хотноо, монгол, вьетнам болон англи хэлээр үйлдсэн бөгөөд эх бичвэр тус бүр нь адил хүчинтэй байна. Гэрээг тайлбарлахад зөрүү гарвал англи хэлээрх эх бичвэрийг баримтална.

МОНГОЛ УЛСЫГ

ТӨЛӨӨЛЖ

Ц.НЯМДОРЖ

**Хууль зүй, дотоод хэргийн
сайд**

**БҮГД НАЙРАМДАХ
СОЦИАЛИСТ ВЬЕТНАМ
УЛСЫГ ТӨЛӨӨЛЖ**

ТО ЛАМ

**Нийгмийн аюулгүй байдлын
сайд, хурандаа генерал**



МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

САНХҮҮГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ХӨТӨЛБӨРИЙН ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, УНГАР УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР

НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ

2019 оны 5 дугаар сарын 10-ны өдөр ноот бичиг солилцсоныг харгалзан Монгол Улсын Засгийн газар болон Унгар Улсын Засгийн газар хооронд 2016 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр Улаанбаатар хотод байгуулсан Санхүүгийн хамтын ажиллагааны ерөнхий хөтөлбөрийн тухай хэлэлцээрт (цаашид “Хэлэлцээр” гэх) дараах нэмэлт, өөрчлөлтийг оруулахаар харилцан тохиролцов.

1. Нөхцөлт тусламжийн зээлээр санхүүжүүлэх төслийн нийт мөнгөн дүнг 32.0 сая ам.доллаароор нэмэгдүүлэх зорилгоор хэлэлцээрийн 3 дугаар зүйлийн эхний өгүүлбэрт “25 сая.ам доллар” гэснийг “57 сая ам.доллар” болгон өөрчлөх;
2. Нэмэлт, өөрчлөлт оруулснаас хэлэлцээрт заасан бусад нөхцөл хэвээр бөгөөд хүчин төгөлдөр үйлчилнэ.
3. Энэхүү нэмэлт өөрчлөлт нь хэлэлцээрийн 11 дүгээр зүйлийн с) хэсэгт заасны дагуу хүчин төгөлдөр болно.

ХЭМЭЭСНИЙГ НОТОЛЖ, энэхүү нэмэлт, өөрчлөлт оруулах гэрээг 2019 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр англи хэлээр хоёр эх хувь үйлдэж, Монгол Улсын Засгийн газар болон Унгар Улсын Засгийн газрын зохих ёсоор эрх олгогдсон төлөөлөгчид гарын үсэг зурж, байгуулав.

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗРЫГ ТӨЛӨӨЛӨН**

**ЧИМЭДИЙН ХҮРЭЛБААТАР
САНГИЙН САЙД**

**УНГАР УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗРЫГ ТӨЛӨӨЛӨН**

**МИХАЙ ГАЛОШФАЙ
УНГАР УЛСААС МОНГОЛ УЛСАД
СУУГАА ОНЦ БӨГӨӨД БҮРЭН
ЭРХТ ЭЛЧИН САЙД**

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 3

Индекс: 200003